

МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ,  
САНГИЙН САЙД, САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ  
ХОРООНЫ ДАРГЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2022 оны .9. дүгээр  
сарын .6. –ны өдөр

Дугаар А-227/А/177/ 408

Улаанбаатар хот

“Монгол Улсын Үндэсний төлбөрийн  
системийг 2022-2026 онд хөгжүүлэх стратеги” батлах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3 дахь заалт, 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсэг; Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг; Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.5 дахь заалт, УИХ-ын 2006 оны 45 дугаар тогтоолоор баталсан Санхүүгийн зохицуулах хорооны дүрмийн 3.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Монгол Улсын Үндэсний төлбөрийн системийг 2022-2026 онд хөгжүүлэх стратеги”-ийг хавсралтаар баталсугай.

2.“Монгол Улсын Үндэсний төлбөрийн системийг 2022-2026 онд хөгжүүлэх стратеги”-ийн хэрэгжилтийг ханган ажиллахыг Монголбанкны Төлбөр тооцооны газар (Э.Анар), Сангийн яамны Төрийн сангийн газар, Санхүүгийн зохицуулах хорооны Банк бус санхүүгийн байгууллагын газар (Б.Итгэлсүрэн)-т тус тус даалгасугай.

3.Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монголбанкны Дотоод аудитын газар (Т.Амарсайхан), Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газар (Б.Доржсэмбэд), Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны дарга (Т.Жамбаажамц)-д тус тус үүрэг болгосугай.





## МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙГ 2022-2026 ОНД ХӨГЖҮҮЛЭХ СТРАТЕГИ

2022 он

## Гарчиг

Товчилсон үгийн жагсаалт .....	4
Товч хураангуй .....	5
1 Үндэсний төлбөрийн систем .....	8
2 Монгол Улсын Үндэсний төлбөрийн системийн шинэчлэл .....	10
2.1 Монгол Улсын ҮТС-ийг 2009-2020 онд хөгжүүлэх стратеги .....	10
2.2 Урагшлах зам .....	11
2.3 Арга зүй .....	11
2.4 Амжилтын хүчин зүйлс .....	12
Монгол Улсын Үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэх стратеги .....	13
2.5 Алсын хараа .....	13
2.6 Өндөр түвшний зорилго .....	13
2.7 Зорилтот түвшин болон шалгуур үзүүлэлтүүд .....	13
2.8 Стратегийн бүрэлдэхүүн хэсгүүд .....	14
2.9 Стратегийн I бүрэлдэхүүн хэсэг: Хүчирхэг институцийн тогтолцоо .....	15
2.9.1 Хууль, эрх зүйн тогтолцоо .....	15
2.9.2 Хяналт .....	17
2.9.3 Хамтын ажиллагаа .....	19
2.10 Стратегийн II бүрэлдэхүүн хэсэг: Үр ашигтай, найдвартай төлбөр тооцооны системийн дэд бүтэц .....	21
2.11 Стратегийн III бүрэлдэхүүн хэсэг: Цахим төлбөрийн хэрэгсэл, үйлчилгээг бүх нийтээр ашиглах .....	27
2.11.1 Төлбөрийн хэрэгслүүд ба үйлчилгээ .....	27
2.11.2 Засгийн газрын төлбөрүүд .....	31
2.11.3 Хил дамнасан төлбөр тооцоо ба гуйвуулга .....	32
3 Хэрэгжүүлэх төлөвлөгөө .....	35
Хавсралт 1 – Арга зүй .....	44
ҮТС-ийн шинэчлэлийн үйл явц .....	44
1 дүгээр үе шат – Нөхцөл байдлыг үнэлж дүгнэх .....	44
2 дугаар үе шат – ҮТС-ийг хөгжүүлэх Стратеги, төлөвлөгөөг боловсруулах .....	44
3 дугаар үе шат: – ҮТС-ийг хөгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилт, хяналт шинжилгээний процесс .....	45
Хавсралт 2: ҮТС-ийн хөгжлийг хэмжих шалгуур үзүүлэлтүүд .....	46
Хавсралт 3: ТЗЗДБХ-ҮЦХОУБ-аас гаргасан Санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн зарчмууд (СЗЗДБЗ) .....	47

Хавсралт 4: ТЗЗДБХ-ҮЦХОУБ-аас гаргасан Санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн цахим аюулгүй байдлыг хангах удирдамж.....	51
Хавсралт 5: Жижиглэнгийн төлбөр тооцооны цогц стратегийг боловсруулах удирдамж.....	52

## 1 Товчилсон үгийн жагсаалт

ACH	Автоматжуулсан клирингийн төв
API	Хэрэглээний програмчлалын интерфейс
ATM	Автомат теллер машин
BOM	Монголбанк
CBV/ТБҮЦ	Төв банкны үнэт цаас
CPMI/ТЗЗДБХ	Олон улсын төлбөр тооцооны банкны Төлбөрийн болон зах зээлийн дэд бүтцийн хороо
CRC/ХХЗХ	Харилцаа, холбооны зохицуулах хороо
CSD/ҮЦТХТ	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв
FATF/ФАТФ	Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага
FRC/СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
FX	Гадаад валютын арилжаа
GDP/ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
IBAN	Олон улсын банкны дансны дугаарлалт
IOSCO/ҮЦХОУБ	Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага
MCSD/МУЦТХТ	Монголын үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв
MOF/СЯ	Сангийн яам
MOU	Харилцан ойлголцлын санамж бичиг
MSCC/МУЦКТ	Монголын үнэт цаасны клирингийн төв
MSE/MXB	Монголын хөрөнгийн бирж
MTOs/MГО	Мөнгөн гуйвуулгын оператор
NBFIs/ББСБ	Банк бус санхүүгийн байгууллагууд
NETC/ҮЦГТ	Үндэсний цахим гүйлгээний төв
NPS/ҮТС	Үндэсний төлбөрийн систем
OTC	Биржээс гадуурх арилжаа /Биржийн бус зах зээлийн арилжаа/
POS	ПОС терминал
PSD/ТТГ	Төлбөр тооцооны газар
PSP/ТҮҮ	Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч
PvP/Тэт	Төлбөрийн эсрэг төлбөр
RTGS	Бодит цагийн горимоор, нэг бүрчлэн гүйцэтгэх төлбөр тооцооны систем буюу Банксүлжээ систем
RTP	Бодит цагийн гүйлгээ
SCHCD	Монголын үнэт цаасны клирингийн төв ба төвлөрсөн хадгаламжийн төв
SSS/ҮЦТТС	Үнэт цаасны төлбөр тооцооны систем

## Товч хураангуй

**Үндэсний төлбөрийн систем (ҮТС) нь санхүүгийн системийн гол бүрэлдэхүүн хэсэг юм.** Энэ нь эдийн засгийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хоорондын төлбөр тооцоог хийж гүйцэтгэх сувгаар хангаж өгдөг дэд бүтэц бөгөөд сайтар төлөвлөсөн төлбөр тооцооны систем нь эрсдэлийг хязгаарлаж, хэрэглэгчдийг хамгаалж, санхүүгийн хямралын нөлөөллийг багасгахад чухал үүрэгтэй. Орчин үеийн төлбөр тооцооны систем, түүний зохицуулалт нь зардал бууруулж, төлбөр тооцоо хийх, санхүүгийн үүргээ гүйцэтгэх хурдыг нэмэгдүүлснээр санхүүгийн салбар, нийгмийн хэрэгцээг хангаж, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулдаг. **ҮТС нь мөнгөн хөрөнгийн болон үнэт цаасны гүйлгээ хийх, боловсруулахтай холбоотой дэд бүтэц, тогтолцооны цогц нэгдэл юм.**

**Монгол Улсын ҮТС-ийн шинэчлэл арав гаруй жилийн өмнө Монголбанкны “Үндэсний төлбөрийн системийг 2009-2014 онд хөгжүүлэх стратеги”-ийг хэрэгжүүлснээр эхэлсэн.** ҮТС-ийг хөгжүүлэх 2009-2014 оны стратегийн гол ололтуудаас дурдвал: Бодит цагийн горимоор, нэг бүрчлэн төлбөр тооцоо гүйцэтгэх Банксүлжээ системийг нэвтрүүлсэн; Монголбанкнаас төлбөрийн системийн талаар баримтлах бодлого болон Төлбөрийн системийн хяналтын бодлогын баримт бичгийг гаргасан; Төлбөрийн системийн оролцогч хоорондын их дүнтэй болон бага дүнтэй төлбөрийн системийн журмыг боловсруулсан; Жижиглэнгийн гүйлгээний залиланг бууруулсан; Цахим төлбөрийн хэрэгслийн хэрэглээг нэмэгдүүлсэн зэрэг явдал юм.

**Монгол Улсын ҮТС-ийн хөгжлийг цаашид удирдан чиглүүлэх зорилгоор 2015-2020 онд дараагийн 5 жилийн стратегийг хэрэгжүүлсэн.** Энэ хугацаанд Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийг боловсруулан батлуулж, цахим мөнгө, төлбөрийн карт, зөвшөөрөл олгох, хяналт тавихтай холбоотой журмуудыг гарган хууль эрх зүйн орчныг бэхжүүлэх чухал алхмыг хийсэн. Түүнчлэн, Банксүлжээ системийн II үеийн шинэчлэл, шууд дебит, кредит шилжүүлэг, бодит цагийн гүйлгээ дэмждэг Автомат клиринг хаус систем, картын гүйлгээний аюулгүй байдал, үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор үндэсний брэнд ₮ карт, картын нэгдсэн системийн шинэчлэлийг тус тус хийсэн байна.

**Төлбөрийн системийн шинэчлэлийг амжилттай хэрэгжүүлснээр олон нийтийн цахим төлбөрийн хэрэгсэлд итгэх итгэлийг бэхжүүлэхэд чухал нөлөө үзүүлсэн.** Хүн амын дийлэнх хувь нь банкин дахь дансаар эсхүл төлбөрийн картаар дамжуулан төлбөр тооцоо хийх болж, үүнийг дагаад иргэдийн интернэт, мобайл банкны хэрэглээ нэмэгдэж, финтекийн төрөл бүрийн шийдлүүд бий болж байна. Монгол Улсын насанд хүрсэн нийт хүн амын 93 хувь нь санхүүгийн байгууллагад данстай болсноор бараг бүх нийтээрээ данс ашигладаг болсон байна.<sup>1</sup> КОВИД-19 цар тахлын нөлөөгөөр цахим төлбөрийн хэрэгслийн хэрэглээ асар хурдацтай өсөж байгаа боловч үүнтэй зэрэгцэн иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн үйлчилгээ, төлбөрийн сувгийг төрөлжүүлэн бий болгох шаардлага үүсэж буйг энд дурдах нь зүйтэй. Үндэсний төлбөрийн системийн 2022-2026 оны стратегийг өнгөрсөн 10 гаруй жилд гарсан ахиц дэвшил, хурдацтай хөгжиж буй олон улсын төлбөрийн систем, Монголын төлбөрийн системийн экосистемд гарч буй чухал өөрчлөлтүүдэд тулгуурлан боловсруулав.

**ҮТС-ийг 2022-2026 онд хөгжүүлэх стратеги илүү аюулгүй, найдвартай, үр ашигтай, хэрэглэгч төвтэй төлбөрийн системийг цогцлоох, төлбөрийн үйлчилгээг цахимжуулахад чиглэсэн болно.** Цахим аюулгүй байдлын эрсдэлээс хамгаалагдсан, 24/7 түргэн шуурхай төлбөр тооцоо хийх боломжтой, хэрэглэгчийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангасан найдвартай төлбөрийн системийн дэд бүтцээр төлбөр тооцоо хийгдэнэ. Санхүүгийн байгууллагад данстай иргэд, төлбөрийн системийн орчин үеийн дэд бүтцэдээ түшиглэн төлбөр тооцооны дийлэнх хувийг цахимжуулах томоохон зорилт тавьж байна. Хил дамнасан

<sup>1</sup> Эх сурвалж: Дэлхийн банкны Глобал финдекс мэдээллийн сан, 2017 он.

жигжлэнгийн гүйлгээ, цахим төлбөрийн үйлчилгээг улс даяар ашиглах боломж бүрдүүлж, үйлчилгээг харьцангуй бага зардлаар үзүүлэх шаардлагатай. Түүнчлэн, төлбөрийн үйлчилгээний зах зээл дэх инновацийг дэмжих, төрийн үйлчилгээг цахимжуулах замаар иргэдийн цахим төлбөр тооцоонд итгэх итгэлийг бэхжүүлэх зорилтыг тавьж байна. Эцэст нь хууль эрх зүйн орчин, төлбөрийн системийн хяналт, хамтарсан хяналтын тогтолцоо нь ҮТС-ийг хөгжүүлэх гол үндэс суурь учир эдгээрийг бэхжүүлэх шаардлагатай юм.

**Энэхүү ҮТС-ийг хөгжүүлэх стратеги нь** (I) Төлбөр тооцоо, клирингийн хүчирхэг институцийн тогтолцоо, (II) Үр ашигтай, найдвартай, аюулгүй байдлыг хангасан төлбөр тооцооны дэд бүтэц, (III) Цахим төлбөрийн хэрэгсэл, үйлчилгээг бүх нийтээр ашиглах гэсэн **стратегийн гурван үндсэн бүрэлдэхүүн хэсгээс** бүрдэнэ. Стратегийн бүрэлдэхүүн хэсэг бүрийн дор тодорхой зорилго, тухайн зорилгод хүрэхэд чиглэсэн хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодорхойллоо. Хүснэгт 1-т энэхүү стратегийн хүрээнд тодорхойлсон бүрэлдэхүүн хэсгүүд, гол зорилтуудыг харуулав.

**Стратегийн I бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд**, Монголбанк төлбөрийн системийн хууль эрх зүйн орчныг бэхжүүлж, шаардлагатай журам, дүрмийг тухай бүр шинэчлэх бөгөөд инновацийг дэмжиж, шинээр үүсэх эрсдэлийг зохистой удирдсан хууль, эрх зүйн орчныг бий болгоход анхаарах болно. Жигжлэнгийн төлбөрийн системд хяналт тавих стандартыг бий болгож, ашиглах, хяналтын бодлогын баримт бичгийг шинэчлэх, тайлан, мэдээ цуглуулах, дүн шинжилгээ хийх автомат систем нэвтрүүлэх, эрх бүхий байгууллагууд хооронд шаардлагатай мэдээлэл солилцож, хамтран ажиллах, ҮТС-ийн зөвлөлөөр дамжуулан нийт оролцогчдын оролцоотойгоор төлбөрийн системийн шинэчлэлийг хийх замаар төлбөрийн системийн хяналт, хамтын ажиллагааг хэрэгжүүлнэ.

**Стратегийн II бүрэлдэхүүн хэсэг нь** байнга хувьсан өөрчлөгдөж буй төлбөрийн системийн дэд бүтэц, төлбөрийн үйлчилгээнд үүсэж буй эрсдэлийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэхэд чиглэнэ. Монголбанк нь төлбөрийн системийн эрсдэлийн удирдлагын цогц тогтолцоог бий болгож, цахим аюулгүй байдлын эрсдэлийг хянах чадавхыг нэмэгдүүлнэ. Энэхүү бүрэлдэхүүн хэсгийн нэг гол зорилт нь хэрэглэгчдийн группээр дамжуулан нийт оролцогчидтой хамтран ажиллах явдал юм.

**Стратегийн III бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд**, Монгол улсын хэмжээнд цахим төлбөрийн үйлчилгээг бүх нийтэд хүргэх зорилгоор Монголбанк нь төлбөрийн систем дэх инновацийг дэмжигч, чиглүүлэгчийн үүрэг гүйцэтгэнэ. Үүний хүрээнд үйлчилгээний нэгдмэл байдлыг хангах, зэх зээл дэх өрсөлдөөнийг дэмжих, хэрэглээг хялбаршуулах зорилгоор төлбөрийн систем дэх стандартчиллын ажлыг эхлүүлэх нэн шаардлагатай байна. Мөн төрийн үйлчилгээг цахимжуулах ажлыг үргэлжлүүлэн хийж, цахим худалдаа, хил дамнасан төлбөр, гуйвуулгын үйлчилгээнд гарч буй саад бэрхшээлийг даван туулах гарцыг олох зорилтыг тавиад байна.

Хүснэгт 1. Стратегийн бүрэлдэхүүн хэсгүүд, зорилт

<b>Стратегийн I бүрэлдэхүүн хэсэг – Хүчирхэг институцийн тогтолцоо</b>	
Зорилт 1	Төлбөр тооцооны систем, төлбөрийн хэрэгсэл, төлбөрийн үйлчилгээний хууль эрх зүйн орчныг бэхжүүлэх
Зорилт 2	Монгол Улсын Үндэсний төлбөрийн системийг бүхэлд нь үр дүнтэй хянах
Зорилт 3	Жигжлэнгийн төлбөрийн систем, төлбөрийн хэрэгсэл, үйлчилгээний хяналтын стандартыг тодорхойлж, ашиглах

Зорилт 4	Эрх бүхий байгууллагууд, төлбөрийн системийн зах зээл дэх хамтын ажиллагааг бэхжүүлэх
<b>Стратегийн II бүрэлдэхүүн хэсэг – Үр ашигтай, найдвартай төлбөр тооцооны системийн дэд бүтэц</b>	
Зорилт 5	ҮТС-ийн үр ашигтай, аюулгүй, найдвартай, тасралтгүй үйл ажиллагааг хангах
Зорилт 6	Үнэт цаасны төлбөр тооцооны систем, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн системд Санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн зарчмыг хэрэгжүүлэх
<b>Стратегийн III бүрэлдэхүүн хэсэг – Цахим төлбөрийн хэрэгсэл, үйлчилгээг бүх нийтээр ашиглах</b>	
Зорилт 7	Инновац, цахим төлбөрийн хэрэглээг дэмжих
Зорилт 8	Төрийн үйлчилгээг цахимжуулах ажлыг үргэлжлүүлэх
Зорилт 9	Хил дамнасан жижиглэнгийн төлбөр тооцооны үр ашиг, хүртээмж, ил тод байдлыг нэмэгдүүлж, хэрэглэгчийн эрхийг хамгаалах

## 2 Үндэсний төлбөрийн систем

**1. Үндэсний төлбөрийн систем (ҮТС) нь санхүүгийн системийн гол бүрэлдэхүүн хэсэг юм.** Энэ нь эдийн засгийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хоорондын төлбөр тооцоог хийж гүйцэтгэх сувгаар хангаж өгдөг дэд бүтэц бөгөөд сайтар төлөвлөсөн төлбөр тооцооны систем нь эрсдэлийг хязгаарлаж, хэрэглэгчдийг хамгаалж, санхүүгийн хямралын нөлөөллийг багасгахад чухал үүрэгтэй. Орчин үеийн төлбөр тооцооны систем, түүний зохицуулалт нь зардал бууруулж, төлбөр тооцоо хийх, санхүүгийн үүргээ гүйцэтгэх хурдыг нэмэгдүүлснээр санхүүгийн салбар, нийгмийн хэрэгцээг хангаж, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулдаг.

**2. ҮТС-д төлбөр болон үнэт цаасны гүйлгээг хийх, боловсруулахтай холбоотой тухайн улсын бүхий л институцийн болон дэд бүтцийн зохицуулалтын матриц хамаарна.**<sup>2</sup> Орчин цагийн ҮТС нь дараах элементүүдээс бүрддэг. Үүнд:

- (i) Иргэн, байгууллагын төлбөрийн дансыг байршуулж, төлбөрийн хэрэгсэл, төлбөрийн үйлчилгээ үзүүлж буй этгээд, мөн төлбөр тооцоотой холбоотой үйлчилгээ үзүүлэгч, зах зээлийн хэрэгцээг хангах төрөл бүрийн бүтээгдэхүүн санал болгож буй байгууллагууд. Үүнд банк, банк бус санхүүгийн байгууллага болон санхүүгийн бус байгууллагууд орно;
- (ii) Төлбөр тооцоо, клирингийн системийн оператор, үйлчилгээ үзүүлэгч гуравдагч этгээдүүд;
- (iii) Төлбөр гүйцэтгэх үйл явц, төлбөрийн системийн зах зээлийн үйл ажиллагааг тодорхойлж, зохицуулдаг хууль тогтоомж, дүрэм журам, гэрээ хэлэлцээрүүд;
- (iv) Кредит шилжүүлэг, шууд дебит, төлбөрийн карт, цахим мөнгө зэрэг төлбөрийн хэрэгсэл, тэдгээрийн зохицуулалт;
- (v) Технологийн дэд бүтэц. Үүнд гүйлгээ дамжуулах, клиринг хийх; төлбөрийн мэдээлэл боловсруулах, дамжуулах; төлбөр төлөгч болон хүлээн авагч байгууллага хооронд мөнгөн хөрөнгө шилжүүлэх; үнэт цаасны цахим бүртгэлийн систем болон хувийн болон Засгийн газрын үнэт цаасны өмчлөлийн өөрчлөлтийг бүртгэх үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн дэд бүтцүүд хамаарна;
- (vi) Клирингийн болон төлбөр тооцооны дүрэм журам, механизм;
- (vii) Хяналтын тогтолцоо, тухайлбал, төлбөрийн системүүд, тэдгээрийн зохицуулалт, төлбөрийн хэрэгсэл, үйлчилгээг эрх бүхий байгууллага хянах тогтолцоо, хамтарсан хяналтын тогтолцоо зэргийг ойлгоно.

**3. ҮТС-ийн элементүүд нь харилцан уялдаа, хамааралтай байдаг.** ҮТС-ийн аль нэг элемент сул талтай байх, эсвэл аль нэг бүрэлдэхүүн хэсгийн өөрчлөлт, шинэчлэлт удаашрахад бусад бүрэлдэхүүн хэсгүүдийг шинэчлэх явц удаашрах, саатах эрсдэлтэй. Иймд төрөл бүрийн систем, зохицуулалтын харилцан хамаарал, уялдаа холбоо, нэгдмэл байдал, хууль эрх зүйн тогтолцоо, эрх бүхий байгууллагуудын хяналтын чадавхыг хамтад нь авч үзэж, ҮТС-ийн шинэчлэлийг цогцоор нь шийдвэрлэх шаардлагатай.

**4. ҮТС-ийг шинэчлэх асуудлыг цогц байдлаар авч үзэхдээ дээрх элементүүдийг бүхэлд нь хамруулсан есөн тулгуур баганад тулгуурлан тодорхойлсон.** (i) Хууль, эрх зүйн тогтолцоо; (ii) Их дүнтэй төлбөр тооцооны систем; (iii) Жижиглэнгийн төлбөр тооцооны системүүд; (iv) Засгийн газрын төлбөрүүд; (v) Валютын арилжаа, банк хоорондын мөнгөний

---

<sup>2</sup> Төлбөр ба зах зээлийн дэд бүтцийн хороо (ТЗЗДБХ)-ны Үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэх ерөнхий удирдамж (2006 он)-ийг харна уу.

зах зээл; (vi) Үнэт цаасны хадгаламж, клиринг, төлбөр тооцооны зохицуулалт; (vii) Олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээ; (viii) Хяналтын тогтолцоо; (ix) Хамтын ажиллагаа.

## 3 Монгол Улсын Үндэсний төлбөрийн системийн шинэчлэл

### 3.1 Монгол Улсын ҮТС-ийг 2009-2020 онд хөгжүүлэх стратеги

5. Монгол Улсын ҮТС-ийн шинэчлэлийг 10 гаруй жилийн өмнө эхлүүлсэн. Монголбанк 2009-2014 оны Монгол Улсын Үндэсний төлбөр тооцооны стратегийн ихэнх зорилтыг амжилттай хэрэгжүүлсэн. Тус стратегийн хүрээнд хийгдсэн гол ажлуудаас дурдвал: Төлбөрийг бодит цагийн горимоор нэг бүрчлэн гүйцэтгэх төлбөр тооцооны систем буюу Банксүлжээ системийг нэвтрүүлсэн; Монголбанкнаас төлбөрийн системийн талаар баримтлах бодлого болон Төлбөрийн системийн хяналтын бодлогыг тодорхойлсон; Төлбөрийн системийн оролцогч хоорондын их дүнтэй болон бага дүнтэй төлбөр тооцооны журмыг тус тус батлан гаргасан; Бага дүнтэй гүйлгээтэй холбоотой хийгддэг залиланг бууруулсан; Бэлэн бус төлбөрийн хэрэгслийн хэрэглээг нэмэгдүүлж чадсан зэрэг юм.

6. Монгол Улсын ҮТС-ийн хөгжлийг цаашид удирдан чиглүүлэх зорилгоор 2015-2020 онд дараагийн 5 жилийн стратегийг хэрэгжүүлсэн. ҮТС-ийг 2015-2020 онд хөгжүүлэх стратеги нь төлбөрийг түргэн шуурхай гүйцэтгэх, найдвартай байдлыг нэмэгдүүлэх зорилгоор мөнгөн хөрөнгийг оролцогч талуудын хооронд шилжүүлэх үр дүнтэй механизмыг бүрдүүлэх; улс орны санхүүгийн тогтвортой байдал, эдийн засгийн өсөлтөд үр дүнтэй хувь нэмэр оруулахуйц системийг хөгжүүлэх; цахим төлбөрийн хэрэгслийн давуу талыг ашиглан бэлэн мөнгөөр хийгдэж буй гүйлгээг бууруулах; системийн эрсдэл болон төлбөр тооцоо, үнэт цаасны системтэй холбоотой үүсэх бусад эрсдэлийг хянах, удирдах, бууруулах, хязгаарлах арга хэмжээ авах; нийгмийн бүхий л салбарт төлбөр тооцооны үйлчилгээг нэвтрүүлж, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн.

7. ҮТС-ийг 2015-2020 онд хөгжүүлэх стратегийн хүрээнд хийгдсэн гол ажлуудаас дурдвал:

- ҮТС-ийн харилцааг цогцоор нь шийдвэрлэх эрх зүйн орчныг бий болгох зорилгоор **Үндэсний Төлбөрийн Системийн тухай хуулийг** баталсан.
- Банксүлжээ системийн үр ашигтай, найдвартай, аюулгүй байдлыг дээшлүүлэхийн тулд төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хадгалах механизм бүхий RTGS системийн **хоёр дахь үеийн шинэчлэлийг** нэвтрүүлсэн.
- Бодит цагийн кредит шилжүүлэг, шууд дебит, багц гүйлгээ боловсруулах зориулалт бүхий **орчин үеийн Автомат клирингийн төв (АСН)**-ийн системийг нэвтрүүлсэн.
- Төлбөрийн картын үйлчилгээний үр ашигтай байдлыг хангах зорилгоор **төлбөрийн картын нэгдсэн сүлжээг** шинэчилсэн.
- Үндэсний брэнд ₮ картын аюулгүй байдал, хэрэглээг дэмжих зорилгоор EMV/NFC технологийг нэвтрүүлсэн.
- **Мөнгөний зах зээл болон гадаад валютын зах зээлд зориулсан** арилжаа, тооцооны нэгдсэн **платформыг** нэвтрүүлж, **Төв банкны үнэт цаасны (ТБҮЦ) төвлөрсөн хадгаламж, төлбөр тооцооны систем** Банксүлжээ системтэй бодит цагийг горимд холбогдон ажилладаг болсон.
- Эрх бүхий байгууллагуудын хамтын ажиллагааны механизмыг сайжруулах зорилгоор Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ), Харилцаа холбооны зохицуулах хороо (ХХЗХ) хамтран Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан.
- Цахим мөнгө, төлбөрийн картын үйлчилгээ үзүүлэгч, клирингийн системийн операторуудад тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих үйл ажиллагааг зохицуулсан **журмуудыг** боловсруулж гаргасан.

- **Төлбөрийн системийн хяналтын жилийн тайланг** нийтлэх замаар Монголбанкны Төлбөрийн системийн хяналтыг хэрэгжүүлэх нэгжийн ил тод байдал, хариуцлагыг нэмэгдүүлсэн.

**8. Төлбөрийн системийн шинэчлэлийг амжилттай хэрэгжүүлснээр иргэн, аж ахуйн нэгжийн цахим төлбөрийн хэрэгсэлд итгэх итгэлийг бэхжүүлэхэд чухал нөлөө үзүүлсэн.** Хүн амын дийлэнх хувь нь банкин дахь дансаар эсхүл төлбөрийн картаар дамжуулан төлбөр тооцоо хийх болж, үүнийг дагаад иргэдийн интернэт, мобайл банкны хэрэглээ нэмэгдэж, финтекийн төрөл бүрийн шийдлүүд бий болж байна. Монгол Улсын насанд хүрсэн нийт хүн амын 93 хувь нь санхүүгийн байгууллагад данстай болсноор бараг бүх нийтээрээ данс ашигладаг болсон байна.<sup>3</sup> КОВИД-19 цар тахлын нөлөөгөөр цахим төлбөрийн хэрэгслийн хэрэглээ асар хурдацтай өсөж байгаа боловч үүнтэй зэрэгцэн иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн үйлчилгээ, төлбөрийн сувгийг төрөлжүүлэн бий болгох шаардлага үүсэж буйг энд дурдах нь зүйтэй.

### 3.2 Урагшлах зам

**9. ҮТС-ийн 2022-2026 оны стратегийг өнгөрсөн 10 гаруй жилд гарсан ахиц дэвшил, шийдэх шаардлагатай асуудлууд, Монголын төлбөрийн системийн экосистемд гарч буй чухал өөрчлөлтүүдэд тулгуурлан боловсруулав.** Технологийн шинэчлэл, хэрэглэгчийн хүсэл сонирхол, бизнесийн шинэ загвар, шинэ төрлийн төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч зэргээс шалтгаалан төлбөрийн системийн зах зээл хурдацтай өөрчлөгдөж байна. Шинэ эрсдэлүүд, цахим аюулгүй байдлын аюул занал нь зохицуулагчид, хянан шалгагчид болон зах зээлд оролцогчдод шинэ сорилт бэрхшээлийг бий болгож байна. Мөн дэлхий нийтийг хамарсан “КОВИД-19” цар тахлын улмаас цахим төлбөр тооцооны эрэлт хэрэгцээ хурдацтай нэмэгдэв.

**10. ҮТС-ийг 2022-2026 онд хөгжүүлэх стратеги нь цахим төлбөр тооцоо давамгайлсан, найдвартай, аюулгүй байдлыг хангасан төлбөрийн систем, үр ашигтай, хэрэглэгч төвтэй төлбөрийн үйлчилгээг бий болгох замд хөтөлнө.** Цахим аюулгүй байдлын эрсдэлээс хамгаалагдсан, 24/7 түргэн шуурхай төлбөр тооцоо хийх боломжтой, хэрэглэгчийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангасан найдвартай төлбөрийн системийн дэд бүтцээр төлбөр тооцоо хийгдэнэ. Санхүүгийн байгууллагад данстай иргэд, төлбөрийн системийн орчин үеийн дэд бүтцэдээ түшиглэн төлбөр тооцооны дийлэнх хувийг цахимжуулах томоохон зорилт тавьж байна. Хил дамнасан жижиглэнгийн гүйлгээ, цахим төлбөрийн үйлчилгээг улс даяар, харьцангуй бага зардлаар ашиглах боломж бүрдүүлэх шаардлагатай. Түүнчлэн, төлбөрийн үйлчилгээний зах зээл дэх инновацийг дэмжих, төрийн үйлчилгээг цахимжуулах замаар иргэдийн цахим төлбөр тооцоонд итгэх итгэлийг бэхжүүлэх зорилтыг тавьж байна. Эцэст нь хууль эрх зүйн орчин, төлбөрийн системийн хяналт, хамтарсан хяналтын тогтолцоо нь ҮТС-ийг хөгжүүлэх гол үндэс суурь учир эдгээрийг бэхжүүлэх шаардлагатай юм.

### 3.3 Арга зүй

**11. ҮТС-ийн шинэчлэлийг дараах гурван шат дарааллыг үргэлжлүүлэн давтах байдлаар хэрэгжүүлдэг.** Үүнд: (i) Нөхцөл байдлын үнэлгээ хийх; (ii) Зорилго, холбогдох гол үзүүлэлтүүдийг тодорхойлж, ҮТС-ийн стратеги, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулах; (iii) ҮТС-ийг хөгжүүлэх төлөвлөгөөг хэрэгжүүлэх, хэрэгжилтийн явцыг хянах шат.

<sup>3</sup> Эх сурвалж: Дэлхийн банкны Глобал финдекс мэдээллийн сан, 2017 он.

Монголбанк ҮТС-ийн 2015-2020 оны стратегийн хэрэгжилтийн явц, төлбөрийн системийн нөхцөл байдлын талаар мэдээлэл цуглуулж, системийн нийт оролцогч талуудтай зөвлөлдсөний үндсэн дээр энэхүү 2022-2026 онд хэрэгжүүлэх стратегийг боловсруулаад байна. Арга зүйн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 1-т тусгасан болно.

### 3.4 Амжилтын хүчин зүйлс

**12. Үр дүнтэй хамтын ажиллагаа.** 2015-2020 оны стратегийг боловсруулж, хэрэгжүүлсэн туршлагаас харахад ҮТС-ийн стратегийг амжилттай хэрэгжүүлэхэд Төв банк болон Засгийн газар гол үүрэг гүйцэтгэх хэдий ч төлбөрийн системийн дэд бүтцийг хөгжүүлэх нь бусад зохицуулагч байгууллагууд, системийн оролцогчид, банкууд, төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч банк бус санхүүгийн байгууллагууд зэрэг бүх оролцогч талуудын хамтын хариуцлага юм. Аливаа өөрчлөлт, шинэчлэлт хийхэд бүх оролцогч талууд идэвхтэй оролцож, хамтран ажиллах зайлшгүй шаардлагатай байдаг. Хамтын ажиллагааг зөв зохион байгуулснаар хамтын хүчин чармайлтыг бий болгож, суралцах үйл явцыг идэвхжүүлж, хамтын ажиллагаа, зөвшилцлийг бий болгох замаар үр ашгийг оновчтой болгох үндэс суурь болж өгдөг. ҮТС-ийн зөвлөл нь шаардлагатай үед ахиц дэвшлийг хурдасгах, төрийн болон хувийн хэвшлийн оролцогч талуудын хоорондын хамтын ажиллагааг бий болгон, өргөжүүлэхэд чухал үүрэгтэй.

**13. Бизнесийн загвар, засаглал болон эрсдэлийн удирдлага.** Аливаа шинэ системийг нэвтрүүлэхдээ бизнес загвар, зардал нөхөх төлөвлөгөөг боловсруулсан байх шаардлагатай бөгөөд оролцогч талууд тухайн шинэчлэлийг хийхэд шаардлагатай зардал болон цаашдын ашиглалтын зардлын (тухайлбал: програм хангамж, тоног төхөөрөмж, ажиллах хүч, сургалт, зөвлөх үйлчилгээ, хяналт, нэмэлт тусламж үйлчилгээ авах гэх мэт) талаар тодорхой ойлголттой байх ёстой. Эрсдэлийн удирдлагын зохистой тогтолцоо нь эрсдэлийг бууруулах, холбогдох зардал хоорондын тэнцвэрийг хадгалахын сацуу төлбөрийн зах зээл дэх эрсдэл, зардлыг тодорхойлж, удирдах нөхцөлийг бүрдүүлдэг. Төлбөрийн систем дэх технологийн шинэчлэлийг дэмжихийн зэрэгцээ шинээр гарч ирж буй эрсдэлүүдэд хяналт-шинжилгээ хийж, үнэлж дүгнэн, хяналт тавих болно.

**14. Оролцоо, үүрэг хариуцлагын тодорхой байдал.** Стратегийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд оролцогч талуудад тодорхой үүрэг, хариуцлага хүлээлгэх шаардлагатай. Монголбанк нь төлбөрийн системийн оператор, зохицуулагч, хянан шалгагч, аливаа хийгдэх шинэчлэлийн хурдасгагч-катализаторын хувьд ҮТС-ийг хөгжүүлэх стратегийн хэрэгжилтийн явцад хяналт тавьж, стратегийг хэрэгжүүлэхэд оролцогч талуудын хамтын ажиллагаа, үйл ажиллагааны үялдаа холбоог дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэнэ. Стратегид хамаарах чиглэлээр зохицуулалтын чиг үүрэг бүхий Сангийн яам, бусад яам, төрийн байгууллагууд ч мөн адил чухал үүрэгтэй. Түүнчлэн төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчид болон системийн операторууд нь системийн нэгдмэл байдлыг хангах, эрсдэлийг удирдах, ил тод байдлыг хангах, зохистой засаглалыг хэрэгжүүлэх, төлбөрийн системийн шинэчлэлийн талаар стратегийн шийдвэр гаргах зэргээр хэрэгжилтийг дэмжинэ. Хамааралтай оролцогч талууд ҮТС-ийн шинэчлэлийг хэрэгжүүлэх тусгайлсан хүний нөөцийг бий болгох, хуваарилах нь стратегийг амжилттай хэрэгжүүлэх чухал үндэс болно. Стратегийн зорилтын хүрээнд хийгдэх ажил тус бүрд зориулан зохион байгуулалтын бүтэц, үүрэг, хариуцлага, төрөл бүрийн оролцогч талуудын хоорондын харилцан уялдааг тодорхойлон, хэрэгжүүлнэ.

## Монгол Улсын Үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэх стратеги

### 3.5 Алсын хараа

*2026 он гэхэд Монгол улс тасралтгүй, найдвартай, аюулгүй төлбөрийн системийн дэд бүтэц болон эрсдэлийг бууруулж, өрсөлдөөн, инновац, үйлчилгээний хүртээмжийг нэн тэргүүнд тавьсан оролцогч байгууллагуудын дэмжлэгтэйгээр цахим төлбөр тооцоо давамгайлсан улс болно.*

### 3.6 Өндөр түвшний зорилго

15. ҮТС-ийг хөгжүүлэх стратегийн хүрээнд дараах зорилгуудыг тавьж байна. Үүнд:

Эдийн засгийн бүхий л оролцогч талууд (Засгийн газар, аж ахуйн нэгжүүд, иргэд, санхүүгийн байгууллагууд) түргэн шуурхай, аюулгүй, найдвартай төлбөрийн үйлчилгээ авна.

Монгол Улс цахим төлбөрийн хэрэгсэл болон финтекийн хэрэглээг түгээн дэлгэрүүлснээр бэлэн мөнгөний хэрэглээ багатай нийгэм рүү шилжилт хийнэ

Үр ашигтай, аюулгүй, нэгдмэл байдлыг хангасан, хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, тасралтгүй, найдвартай ажиллагаа бүхий төлбөр тооцооны дэд бүтэцтэй болно.

Хууль тогтоомж, дүрэм журам нь тэнцвэртэй, төлбөрийн систем, хэрэглэгчийн эрхийг хамгаалж, төлбөрийн үйлчилгээний өрсөлдөөн, инновацийг дэмжинэ.

Эрх бүхий байгууллагууд төлбөрийн систем, төлбөрийн үйлчилгээ, хэрэгсэлд үр дүнтэй хяналт тавина.

Төлбөрийн системийн экосистем дэх бүх оролцогч талууд хамтран ажиллаж, шинэчлэлийг хийнэ.

### 3.7 Зорилтот түвшин болон шалгуур үзүүлэлтүүд

Стратегийн ололт, амжилтыг хэмжих зорилгоор дор жагсаасан **шалгуур үзүүлэлтүүдийг** ашиглана. 2026 оны сүүлийн байдлаар, дараах үр дүнд хүрнэ. Үүнд:

- Нэг хүнд ногдох бэлэн бус гүйлгээний тоог 30 хувиар өсгөх;
- Орон нутаг дахь ПОС терминал, цахим мөнгө хүлээн авагчийн тоог 40 хүртэл хувиар өсгөж, цахим төлбөрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх;
- Цахим эрсдэлийг удирдах олон улсын стандартыг нэвтрүүлэх;
- Системийн хувьд нэн чухал төлбөрийн систем, санхүүгийн зах зээлийн дэд бүтцүүд “Санхүүгийн зах зээлийн бүтцийн зарчмууд” болон бусад холбогдох стандартыг хангаж байгаа эсэхэд тогтмол үнэлгээ хийх;

- Валютын арилжааны төлбөр тооцоог Төлбөрийн эсрэг төлбөр (ТЭТ) зарчмын дагуу хийж, төлбөр тооцооны эрсдэлийг бууруулах;
- Төлбөр тооцооны одоогийн болон шинэ систем (платформ), төлбөрийн хэрэгслийн харилцан зохицолдоог хангах;
- Засгийн газрын төлбөр тооцоо цахимжиж, ҮТС-д нэгдсэн байх;
- Цахим төлбөрийн үйлчилгээг Монгол Улсын нийт хүн амд хүртээмжтэй болгож, хэрэглээг нэмэгдүүлэх;
- Олон улсын мөнгөн гуйвуулга, хил дамнасан жижиглэнгийн гүйлгээний үр ашгийг нэмэгдүүлэх, хураамж шимтгэлийг бууруулахад дэмжлэг үзүүлэх;

Түүнчлэн, Монголбанк чиг хандлагыг тодорхойлох, үндсэн шалгуур үзүүлэлтүүдийн үнэлгээ хийхэд туслах завсрын шалгуур үзүүлэлтүүдийг Хавсралт 2-т тодорхойлов. Эдгээр үзүүлэлтүүдийг тогтмол хэмжиж (6, 12 сар тутамд) хяналт-шинжилгээний тайланд тусгана.

### 3.8 Стратегийн бүрэлдэхүүн хэсгүүд

16. ҮТС-ийг хөгжүүлэх стратегийг дараах гурван үндсэн бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд боловсруулсан:

- I. Төлбөр, тооцоо, клирингийн хүчирхэг институцийн тогтолцоо
- II. Үр ашигтай, аюулгүй байдлыг хангасан төлбөр тооцооны дэд бүтэц
- III. Цахим төлбөрийн хэрэгсэл, үйлчилгээг бүх нийтээр ашиглах

17. Стратегийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрийн хүрээнд тодорхой зорилтыг тавьж, тухайн зорилтын хүрээнд хийгдэх үйл ажиллагааг тодорхойлсон болно. Зураг 2-т өмнө дурдсан 9 тулгуур багана стратегийн гурван бүрэлдэхүүн хэсэгт хэрхэн хамаарахыг харуулав.

**Зураг 1 Стратегийн бүрэлдэхүүн хэсгүүд ба тулгуур багана.**



## 3.9 Стратегийн I бүрэлдэхүүн хэсэг: Хүчирхэг институцийн тогтолцоо

### 3.9.1 Хууль, эрх зүйн тогтолцоо

#### Нөхцөл байдал

**18. Зохистой, пропорциональ хууль эрх зүйн тогтолцоо нь найдвартай, үр ашигтай ҮТС-ийн үндэс гэж үздэг.** ҮТС-ийн зохистой, оновчтой хууль эрх зүйн тогтолцоог бий болгоход тухайн улс орны хууль, эрх зүйн орчин нь дараах асуудлуудыг авч үзсэн байх шаардлагатай. Үүнд: i) төлбөрийн чадваргүй болох, талуудын хоорондох гэрээний харилцаа зэрэг асуудлыг шийдвэрлэх өргөн хүрээг хамарсан хууль тогтоомж; ii) цахим гарын үсэг, үр дүнгийн төлбөр тооцооны хүчин төгөлдөр байдал, төлбөр тооцооны эцэслэлт зэрэг төлбөрийн систем, төлбөрийн хэрэгслийг зохицуулсан тодорхой хууль тогтоомж, журам; iii) төлбөрийн системийн оролцогчид мөрдөхөөр хүлээн зөвшөөрсөн дүрэм, журам, стандарт; iv) төв банк, зохицуулагч байгууллагад төлбөрийн систем, төлбөрийн хэрэгсэл, үйлчилгээг хянах, зохицуулах бүрэн эрх олгож, үүрэг хариуцлагыг тодорхойлсон хууль, дүрэм журам.

**19. Төлбөрийн системийн хууль эрх зүйн орчны тогтвортой байдалд нөлөөлөх, төлбөрийн системийн хууль эрх зүйн зохицуулалттай нийцсэн байх шаардлагатай хууль тогтоомжид: ил тод байдлын тухай болон төлбөрийн хэрэгслийн аюулгүй байдлын тухай хууль; төлбөрийн үйлчилгээн дэх монополийн эсрэг хууль; төлбөрийн системийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах болон хувийн нууцын тухай хуулиуд багтана.** Шинэлэг төлбөрийн хэрэгсэл, сувгууд, Финтекийн шийдлүүд, шинэ төрлийн төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчид бий болж байгаа тул төлбөрийн аюулгүй байдал, мэдээллийн нууцлал, хэрэглэгчийг хамгаалах, МУТСТ-тэй (AML/CFT) холбоотой нэмэлт зохицуулалтууд мөн хийгдэх шаардлагатай болж байна.

#### Монгол Улсын төлөв байдал

**20. ҮТС-ийг 2015-2020 онд хөгжүүлэх стратегийн гол ололт нь Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийг 2017 онд баталж, төлбөрийн системийн үйл ажиллагаа, харилцагчдад төлбөрийн үйлчилгээ үзүүлэх эрх зүйн орчныг бэхжүүлсэн явдал байв.** ҮТС-ийн тухай хуулиар Монголбанканд ҮТС-ийг удирдан зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих бүрэн эрхийг олгосон. Төлбөр тооцооны эцэслэлт, үр дүнгийн төлбөр тооцооны хүчин төгөлдөр байдал болон барьцаа хөрөнгийг хамгаалах; төлбөр төлөгч, төлбөр хүлээн авагчийн эрх ашгийг хамгаалах; системийн оролцогч болоход ижил тэгш шаардлага тавих; шинэлэг төлбөрийн хэрэгсэл, үйлчилгээг хөгжүүлэх эрх зүйн орчныг тодорхой болгосон. Түүнчлэн, төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч болон системийн операторууд аутсорсингийн үйлчилгээ авах, гэрээт төлөөлөгчөөр дамжуулан төлбөрийн үйлчилгээ үзүүлэх зэргээр гуравдагч этгээдээс үйлчилгээ авах, тэдгээрт хяналт тавих эрх зүйн зохицуулалтыг бий болгосон. ҮТС-ийн тухай хууль нь төлбөрийн үйлчилгээ үзүүлж буй банк, банк бус санхүүгийн байгууллагын ижил тэгш оролцоог хангаж, эрсдэлд суурилсан хяналт, зохицуулалт хийх боломж бүрдүүлсэн.

**21. Монголбанк ҮТС-ийн тухай хуулийн хүрээнд цахим мөнгө, төлбөрийн карт болон төлбөрийн системийн операторын үйл ажиллагааг зохицуулсан журмуудыг тус тус гаргасан:** (i) Эхний журмаар Монгол улсад цахим мөнгө гаргах, цахим мөнгийг мөнгөн хөрөнгөнд, мөнгөн хөрөнгийг цахим мөнгөнд хөрвүүлэх үйл ажиллагаа болон цахим мөнгө гаргагчдын хүлээх үүргийг нарийвчлан зохицуулсан; (ii) Төлбөрийн картын тухай журамд төлбөрийн карт гаргах, хүлээн авах, картын клиринг, төлбөр тооцоо хийхтэй холбоотой зохицуулалтыг тусгасан; (iii) Системийн операторуудад зориулсан журмаар клирингийн оператор, төлбөр тооцооны төлөөлөгчид зөвшөөрөл олгох, үйл ажиллагаанд тавигдах шаардлага, хариуцлага, маргаан шийдвэрлэх, бүртгэл хөтлөх зэрэг үйл ажиллагааг тус тус зохицуулсан.

**22. ҮТС-ийн тухай хууль 2017 онд батлагдсан нь том алхам байсан ч төлбөрийн системийн экосистем хурдацтай өөрчлөгдөж байгаатай холбоотойгоор төлбөрийн системийн эрх зүйн орчинд шийдэх шаардлагатай асуудлууд гарч ирсээр байна.** Сүүлийн жилүүдэд дэлхий даяар олон төрлийн финтек үйлчилгээнүүд төрөн гарч, инновацлаг төлбөрийн шийдлүүд бий болсноор олон давуу талыг бий болгож байгаа ч үүнтэй зэрэгцэн шинэ төрлийн эрсдэлүүд гарч ирж байна. Үүнтэй зэрэгцэн зохицуулагч байгууллагууд инновацийг дэмжих, эрсдэлийг зохистой удирдах зорилгоор өөрийн хууль эрх зүй, зохицуулалтын орчныг хурдацтай шинэчлэх шаардлага үүсэж байна. Манай улсын хувьд ч мөн адил ҮТС-ийн тухай хууль батлагдаад удаагүй ч шинэ сорилт бэрхшээл, эрсдэлүүд үүсэж байгааг дурдах нь зүйтэй.

**23. Журмуудын давхцалыг арилгах, шинээр гарч ирж буй үйлчилгээнүүдийн зохицуулалтын орчныг бий болгох, ил тод болгох зорилгоор Монголбанк хяналт шалгалт хийх, зөвшөөрөл олгох үйл ажиллагааг бүхэлд нь зохицуулсан нэгдсэн журмын төслийг боловсруулж байна.** Энэхүү журмаар бүхий л төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч, системийн оператор, төлбөрийн хэрэгсэл гаргагч нарын үйл ажиллагааг зохицуулах ба батлагдсан өдрөөс эхлэн өмнө гаргасан зарим журмуудыг хүчингүй болгох юм.

**24. Хууль эрх зүй, зохицуулалтын орчинд гарч буй бусад өөрчлөлтөөс дурдвал:** (i) Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийг 2021 оны 5 дугаар сард шинэчлэн баталснаар цахим мөнгөний дансыг харилцах данс гэж үзэх, эдгээр дансанд хүү тооцохгүй байх, зөвхөн төлбөр илгээх, хүлээн авах зорилгоор ашиглах боломжтой бөгөөд хадгаламж гэж тооцохгүй байхаар хуульчилсан; (ii) санхүүгийн салбар дахь хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төслийг Улсын Их хуралд өргөн мэдүүлээд байна; (iii) Хүний хувийн мэдээлэл хамгаалах хуулийн төслийг УИХ-аар хэлэлцүүлэхээр өргөн барьсан бөгөөд 2022 онд батлагдах төлөвтэй байна. Эдгээр шинэ болон шинэчлэн найруулсан хуулиуд батлагдсанаар төлбөрийн системийн эрх зүйн орчинд тодорхой хэмжээгээр нөлөөлөх бөгөөд эдгээртэй уялдуулан холбогдох журам, дүрэмд өөрчлөлт оруулах шаардлагатай. Харилцагчийн эрх ашгийг хамгаалах, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах нь төлбөрийн системийн зохицуулалтын тогтолцооны чухал хэсэг бөгөөд харилцагчдад эрх тэгш хандаж, хувийн нууцаа алдах, залилан мэхлүүлэх, зөвшөөрөлгүй хураамж шимтгэл төлөх эрсдэлээс хамгаалснаар шинээр гарч буй цахим төлбөрийн хэрэгсэл, үйлчилгээнд итгэх итгэлийг бий болгоно.

**25. ҮТС-ийн тухай хуулийг хэрэгжүүлэх явцад хуулийн давхардал, зохицуулагдаагүй асуудлууд гарч ирж байгаа тул эдгээрийг шийдвэрлэх шаардлагатай.** Монголбанк нь ҮТС-ийн тухай хуулийн дагуу ҮТС, түүний бүрэлдэхүүн хэсгүүдийг удирдан, зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих бүрэн эрхтэй. Энэхүү бүрэлдэхүүн хэсэгт системийн оператор, төлбөрийн үйлчилгээ үзүүлж буй банк, хуулийн этгээдүүд хамаарах бөгөөд цахим мөнгө гаргагч, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд мөн багтана. Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох нь Монголбанкны бүрэн эрхийн нэг юм. Үүний зэрэгцээ 2002 онд батлагдсан Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн дагуу СЗХ нь ББСБ болон санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж буй бусад банк бус хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих, тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, цуцлах бүрэн эрхтэй байна. Үүний улмаас, төлбөрийн үйлчилгээ үзүүлж буй банк бус санхүүгийн байгууллагууд хоёр тусгай зөвшөөрлийг Монголбанк, СЗХ-ноос давхардуулж авах шаардлагатай болсон. Энэхүү асуудлыг шийдэх зорилгоор 2021 онд Монголбанк, СЗХ, ХХЗХ хамтран санамж бичиг байгуулсан бөгөөд банк бус төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчид тусгай зөвшөөрөл олгох чиг үүргийг хэрхэн хуваарилахыг тодорхой тусгасан. Үүний дагуу мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэгчээс бусад банк бус төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчид Монголбанкнаас тусгай зөвшөөрөл авч байна. Цаашид энэхүү асуудлыг хуулийн давхардлыг арилгах замаар шийдвэрлэх шаардлагатай.

## Зорилго ба гол арга хэмжээ

### ЗОРИЛГО # 1: ТӨЛБӨР ТООЦООНЫ СИСТЕМ, ТӨЛБӨРИЙН ХЭРЭГСЭЛ БОЛОН ТӨЛБӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ, ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧНЫГ БЭХЖҮҮЛЭХ

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа 1.** СЗХ-той хамтран банк бус төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчдэд тавих хяналт, шалгалтын уялдаа холбоог сайжруулах зорилгоор одоо мөрдөгдөж буй хуулиудад дүн шинжилгээ хийж, нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг өргөн барих;

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа 2.** Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч, системийн операторт зөвшөөрөл олгох, хяналт тавих үйл ажиллагааг цогцоор нь зохицуулсан нэгдсэн журам гаргах;

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа 3.** Инновацийг дэмжиж, төлбөрийн зах зээлд гарч ирж буй шинэ төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээг хамруулсан, түүнтэй холбоотой гарч ирэх эрсдэлийг үр дүнтэй удирдах төлбөрийн системийн хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх;

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа 4.** Санхүүгийн мэдээллийг банк, банк бус төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нар солилцон, харилцан ашиглах боломжтой нээлттэй банкны (open banking) үйлчилгээг дэмжсэн хууль эрх зүйн зохицуулалт бий болгох хэрэгцээ шаардлагыг судлах;

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа 5.** Санхүүгийн салбарын харилцагчдыг хамгаалах тухай шинэ хуультай холбоотойгоор, банк бус төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч, төлбөрийн хэрэгсэл гаргагч нарт тавигдаж буй хэрэглэгчийн эрхийг хамгаалах шаардлагад нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай эсэхийг үнэлэх;

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа 6.** Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай шинэ хуультай нийцүүлэн төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нарт тавигдах мэдээллийн нууцлал, аюулгүй байдлын талаар нэмэлт шаардлагыг холбогдох журмуудад тусгах шаардлагатай эсэхийг үнэлэх.

#### 3.9.2 Хяналт

##### Нөхцөл байдал

**26. Төлбөр тооцооны системийн ач холбогдол өсөн нэмэгдэж, шинэлэг төлбөрийн хэрэгслүүд бий болохын хэрээр төв банкны зүгээс төлбөрийн системийн зохистой хяналт тавих шаардлагатай болдог. Үндэсний төлбөрийн системд тавих хяналт нь эдийн засаг дахь санхүүгийн тогтвортой байдлыг хангах, үндэсний мөнгөн тэмдэгтэд итгэх итгэлийг хадгалахад чиглэсэн Төв банкны өргөн хүрээний хариуцлагын нэг хэсэг юм. Хяналтын чиг үүрэг нь системд үүсэж болзошгүй эрсдэлээс хангалттай түвшинд хамгаалж, системээр иргэн, байгууллага, санхүүгийн зах зээл хооронд мөнгөн хөрөнгө түргэн шуурхай, аюулгүй дамжиж, үр ашигтай ажиллуулах үндсэн зорилготой.**

**27. Санхүүгийн бусад салбарын адил төлбөрийн системийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх олон улсын стандартыг нэвтрүүлэх, шилдэг туршилагуудад нийцүүлэх шаардлагатай. Эдгээр стандартыг ТЗЗДБХ-оос гаргасан Төв банкнаас төлбөр тооцооны системд тавих хяналтын тайлан (2005), ТЗЗДБХ-ҮЦХОУБ-аас гаргасан Санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн зарчмуудад тодорхойлсон системийн хувьд нэн чухал СЗЗДБ-ийн эрх бүхий байгууллагуудын таван үүрэг хариуцлагад тодорхойлж өгсөн (Хавсралт 3). Жижиглэнгийн төлбөрийн системд мөн СЗЗДБЗ-ын зарим зөвлөмжийг ашиглаж болно.**

**28. Технологийн өөрчлөлт, зах зээл дэх шинэ тоглогчдын нөлөөгөөр Төв банкнаас төлбөрийн систем, төлбөрийн хэрэгсэлд тавих хяналтын хамрах хүрээ, шаардлага огцом нэмэгдэж, өөрчлөгдөж байна.** Төв банкууд төлбөрийн систем, төлбөрийн үйлчилгээ, хэрэгсэлд гарч буй инновацууд нь үр ашгийг дээшлүүлж, зардлыг бууруулахын зэрэгцээ аюулгүй байдлыг хангаж буй эсэхэд үнэлгээ хийх шаардлагатай. Одоогийн төлбөрийн системийн хяналтын зарим үзэл баримтлал, арга зүйг инноваци, шинэ төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчид, Финтек компаниуд, шинэ үйлчилгээ, бизнес загваруудад ашиглахад тохиромжгүй байгаа бөгөөд инноваци хурдацтай хөгжиж буй энэ үед төв банкууд хурдтай хариу үйлдэл үзүүлэх чадвараа сайжруулж, гарч ирэх боломж, аюул заналыг үнэлэхэд шаардлагатай чадавхаа нэмэгдүүлэн, хяналтын бодлого, үйл ажиллагаа, арга хэрэгслээ тогтмол үнэлж, шинэчлэх шаардлагатай юм. Зохицуулагч байгууллагууд, хянан шалгагч нарын хувьд шинэ технологи гарч ирэхийн хэрээр цахим эрсдэлийн удирдлага, хэрэглэгчийн мэдээллийг хамгаалах нь тулгамдаж буй гол асуудал болоод байна.

#### Монгол Улсын төлөв байдал

**29. Монголбанк төлбөрийн системийн хяналтын нэгжийг бие даасан хэлтэс болгон зохион байгуулсан.** ҮТС-ийг 2015-2020 онд хөгжүүлэх стратегийн дагуу ҮТС-ийн тухай хуулиар олгосон ҮТС-ийг удирдах, зохицуулах, хянах бүрэн эрхээ хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Хяналт зохицуулалтын хэлтэс (ХЗХ)-ийг Төлбөр тооцооны газар (ТТГ)-г байгуулаад байна. Төлбөрийн системийн хяналтын бодлого, Хяналтын гарын авлагыг боловсруулан батлуулж, хянан шалгагчдыг тогтмол сургалтад хамруулан, хүний нөөцийн чадавхаа нэмэгдүүлсэн.

**30. Төлбөрийн системийн хяналтын бодлогын баримт бичгийг 2021 онд шинэчлэн баталсан.** Хяналтын бодлогыг 2017 онд баталснаас хойш төлбөр тооцооны салбарт төлбөрийн шинэ хэрэгсэл, сувгууд, шинэ тоглогчид гарч ирж, технологийн дэвшил хийгдэн, КОВИД-19 цар тахлын улмаас үйл ажиллагааны орчин хүртэл өөрчлөгдөж байна. Энэ нь хэдийгээр илүү сайн, түргэн шуурхай, хямд, хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх зорилготой ч шинэ төрлийн эсвэл хувьсан өөрчлөгдсөн эрсдэлүүдийг бий болгож, хянан шалгагчдад шинэ сорилт бий болгож байгаа юм. Үүнтэй холбоотойгоор Төлбөрийн системийн хяналтын бодлогын баримт бичгийг 2021 онд шинэчлэн батлав.

**31. Хянан шалгагчдын чадавх, ур чадварыг дээшлүүлэхэд ихээхэн хүчин чармайлт гаргаж байгаа ч ҮТС-ийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төлбөр тооцооны салбарт гарч буй ахиц дэвшилтэй холбоотойгоор хяналт шалгалтын нэмэлт нөөц бололцоо бий болгохыг шаардаж байна.** ҮТС-ийн тухай хууль батлагдсанаас хойш 3 жилийн хугацаанд тусгай зөвшөөрөл хүссэн 20 гаруй хүсэлт хүлээн авч, 10 гаруй тусгай зөвшөөрөл олгоод байна. Технологийн дэвшил, түүнийг дагасан инноваци, олон шат дараалал бүхий төлбөр тооцооны тогтолцоо зэргээс болж ХЗХ-ийн хянан шалгагчдаас илүү өндөр ур чадвар шаардаж байна.

**32. Монголбанк системийн хувьд нэн чухал Банксүлжээ систем, ТБҮЦ-ны төлбөр тооцоо, хадгаламжийн системд ТЗЗДБХ-ҮЦХОУБ-аас гаргасан СЗЗДБЗ-ийг баримтлах талаар холбогдох бодлогын баримт бичигт тусгасан.** ХЗХ нь СЗЗДБЗ-ын дагуу Банксүлжээ систем, Монголбанкны хариуцан ажиллуулдаг ТБҮЦ-ны төлбөр тооцоо, хадгаламжийн системийн үнэлгээг тогтмол хийж, үнэлгээний үр дүнг Монголбанкны жилийн тайланд тусгадаг. Одоогоор системийн хувьд нэн чухал бус жижиглэнгийн төлбөрийн системд ашиглах хяналтын стандартыг тодорхойлоогүй байна.

## Зорилго ба гол арга хэмжээ

### ЗОРИЛГО # 2: МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙГ БҮХЭЛД НЬ ҮР ДҮНТЭЙ ХЯНАХ

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа 1.** Төлбөрийн системийн зах зээл дэх хөгжлийг цогцоор нь авч үзэн, шаардлагатай тохиолдолд Төлбөрийн системийн хяналтын бодлогыг шинэчлэх;

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа 2.** Оролцогч, операторуудаас авч буй тайлан, тоон мэдээг нягталж, төлбөрийн систем дэх чиг хандлага, эрсдэл, төлбөрийн системийн зах зээл, төлбөрийн хэрэгслийн хөгжилд дүн шинжилгээ хийхэд шаардлагатай нэмэлт статистик мэдээллийг тодорхойлох;

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа 3.** Төлбөрийн системтэй холбоотой авч буй тайлан мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх ажлыг автоматжуулах;

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа 4.** ТТГ-ын хянан шалгагч, бодлогын мэргэжилтний нөөцийг нэмэгдүүлж, шинээр гарч ирж буй эрсдэл, төлбөрийн системийн чиг хандлага, шинэлэг төлбөрийн хэрэгсэл, схемүүд болон үр дүнтэй хяналт тавих олон улсын стандартын талаар өргөн хүрээний ойлголт өгч, техникийн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн чадавх бэхжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх.

### ЗОРИЛГО # 3: ЖИЖИГЛЭНГИЙН ТӨЛБӨРИЙН СИСТЕМ, ХЭРЭГСЛҮҮД БОЛОН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОЛОН УЛСЫН ХЯНАЛТЫН СТАНДАРТ НЭВТРҮҮЛЭХ

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа 1.** СЗЗДБЗ-ын дагуу Банксүлжээ систем, ТБҮЦ-ны үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн үйл ажиллагаанд хийх үнэлгээг тогтмол хийх;

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа 2.** Монголбанк нь олон улсын стандарт, шилдэг туршлагад нийцүүлэн жижиглэнгийн төлбөрийн систем, төлбөрийн хэрэгсэл, үйлчилгээ, тэр дундаа шинэлэг төлбөрийн хэрэгсэл, схемд зориулсан стандартуудыг нэвтрүүлэх;

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа 3.** Монголбанк жижиглэнгийн төлбөрийн систем, төлбөрийн хэрэгсэл, үйлчилгээ нь стандартад нийцэж байгаа эсэх үнэлгээг тогтмол хийх.

#### 3.9.3 Хамтын ажиллагаа

##### Нөхцөл байдал

**33. УТС-ийг оновчтой, үр ашигтай хөгжүүлэхэд зохицуулагч байгууллага, зах зээлд оролцогч хоорондын болон зохицуулагчид хоорондын хамтын ажиллагаа чухал үүрэгтэй. Хамтарсан хяналт шалгалт, мэдээлэл солилцох зохицуулалтын хэм хэмжээг бий болгосноор мэдээлэл солилцоход саад учрах, байгууллагуудын хамтын ажиллагаанд зөрчилдөөн үүсэх эрсдэлийг бууруулж чадна. Хяналтын чиг үүргийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд төв банкны хянан шалгагчид дараах этгээдүүдтэй тогтмол хамтран ажиллаж, зөвлөлдөх шаардлагатай:**

- Төлбөр, гүйлгээ, клиринг, тооцооны системийн холбогдох асуудалд хяналт тавих зарим чиг үүргийг төв банктай хуваалцдаг бусад зохицуулагч байгууллага, хянан шалгагчид. Эдгээр нь төв банкны бусад газар хэлтэс эсхүл бусад зохицуулагч байгууллагууд байж болно.

- *Операторууд, системийн нөлөө бүхий оролцогчид, бусад төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нараас бүрдсэн хамтын ажиллагааны бүлгэм, ажлын хэсэг. Энэ нь нийт оролцогч талуудыг хамруулсан, үр дүнтэй хэлэлцүүлэг явуулахад чухал ач холбогдолтой.*

- *Бусад орны төв банк, олон улсын байгууллагууд. Олон улсад хэрэглэж болох хяналтын бодлого, стандарт боловсруулахад чухал үүрэгтэй. Инноваци, хил дамнасан гүйлгээ нэмэгдэхийн хэрээр олон улсын түвшинд хамтран ажиллах, салбар салбарын эрх бүхий байгууллагууд хоорондын болон эрх бүхий байгууллага, салбарын тоглогчид хооронд хамтран ажиллах хэрэгцээ шаардлага нэмэгдэж байна.*

## Монгол Улсын төлөв байдал

**34. ҮТС-ийн Зөвлөл нь эрх бүхий байгууллагууд, хувийн хэвшил хоорондын хамтын ажиллагааны үндсэн форум юм.** Зөвлөл жилдээ нэг удаа хуралдаж, ҮТС-д тулгарч буй сорилт, бэрхшээл болон боломжуудын талаар хэлэлцдэг хэдий ч, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгоход чиглэсэн бодлого, удирдамж чиглэл, зөвлөмж, төлбөрийн ирээдүйн чиг хандлага, төлбөрийн системийн нийгэм-эдийн засагт үзүүлэх нөлөөллийн талаар салбарынхантай зохион байгуулалттайгаар, тогтмол зөвлөлддөггүй тул салбарын тоглогчдын туршлага, мэдлэгийг бүрэн ашиглаж чадахгүй байна.

**35. Монголбанк, СЗХ, ХХЗХ тус тусын бүрэн эрхийнхээ хүрээнд үйл ажиллагаа явуулж буй банк, ББСБ-уудад тавих хяналт, шалгалтын чиглэлээр хамтран ажиллах тухай Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулаад байна.** Тус санамж бичигт бэлэн бус төлбөр тооцоог дэмжих, технологийн дэвшлийг ашиглан ҮТС-ийг хөгжүүлэх, ҮТС дэх хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх, тайлан мэдээг сайжруулах, санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний тоон мэдээ, мэдээлэл солилцох, ҮТС дэх эрсдэлийг удирдах чиглэлээр эрх бүхий гурван байгууллага хамтран ажиллах, үүний хүрээнд хүлээх үүргийг тусгасан. Гэвч Үнэт цаасны төлбөр тооцооны үйл ажиллагааны талаар санамж бичигт тусгаагүй байна. ҮТС-ийн хяналт нь санхүүгийн зах зээлийг бүхэлд нь хамардаг тул СЗХ-ны хяналтад байдаг Үнэт цаасны төлбөр тооцооны үйл ажиллагаанд Монголбанкнаас хамтарсан хяналт тавих, СЗХ-той хамтран ажиллах явдал нэн чухал юм.

## Зорилго ба гол арга хэмжээ

### **Зорилго # 4: ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГУУД ХООРОНДЫН БОЛОН САЛБАРЫН БУСАД БАЙГУУЛЛАГУУДАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ ЗОХИЦУУЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ**

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа 1.** Монголбанк, СЗХ хооронд мэдээлэл солилцох, хяналт шалгалтын хүрээнд хамтран ажиллах талаар нарийвчлан тусгасан санамж бичиг байгуулан, ҮЦТТС-д хамтарсан хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх. Ингэснээр Монголбанк ҮТС-ийн тухай хуулийн дагуу хяналтын чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэх боломжтой болох юм;

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа 2.** Монголбанк, СЗХ, ХХЗХ хамтран байгуулсан санамж бичгийн хүрээнд тайлан, мэдээлэл солилцох, хамтарсан хяналт шалгалтыг үр ашигтай зохион байгуулж, хэрэгжүүлэх;

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа 3.** ҮТС-ийн Зөвлөлөөр дамжуулан нийт гишүүдтэй мэдлэг, туршлага хуваалцан, тэдгээрийн зах зээл, техникийн мэдлэгийг бүрэн ашиглаж, бодлогын шийдвэр гаргалтад ашиглах замаар төлбөрийн системийн шинэчлэлийг хийх. Үүнтэй холбогдуулан, Монголбанк “Үндэсний төлбөрийн системийн зөвлөлийн дүрэм”-ийг хянан үзэж, шаардлагатай гэж үзвэл нэмэлт өөрчлөлт оруулах.

### 3.10 Стратегийн II бүрэлдэхүүн хэсэг: Үр ашигтай, найдвартай төлбөр тооцооны системийн дэд бүтэц

#### Нөхцөл байдал

36. **Аюулгүй, найдвартай, үр ашигтай төлбөр тооцооны дэд бүтэц нь санхүүгийн тогтвортой байдал, эдийн засгийн өсөлтөд хувь нэмэр оруулахад чухал үүрэг гүйцэтгэдэг.** Төлбөр тооцооны дэд бүтэц нь их дүнтэй болон жижиглэнгийн төлбөрийн систем, мөнгө, хөрөнгө, валютын арилжааны зах зээл дэх гүйлгээний клиринг, төлбөр тооцоог явуулж буй дэд бүтцээс бүрддэг. Эрсдэлийн удирдлага, үйл ажиллагааны тасралтгүй, найдвартай байдалд тавих өндөр шаардлагад нийцүүлэн клиринг, төлбөр тооцооны системийг боловсронгуй болгох, хөгжүүлэх, технологийн дэвшилийг ашиглах замаар үр ашгийг нэмэгдүүлэх нь улс орны хувьд нэн чухал. Эдийн засаг, санхүүгийн тогтвортой байдалд төлбөр тооцооны дэд бүтцийн ач холбогдол сүүлийн жилүүдэд нэмэгдэж байгаатай зэрэгцэн мэдээлэл, харилцаа холбооны технологи хурдацтай хөгжиж, төлбөр тооцооны салбарт олон төрлийн инновац гарч ирж байгаагаас цахим эрсдэлийг цаг алдалгүй илрүүлж, арга хэмжээ авах чадвар төв банкуудад нэн чухал болж байна. ТЗЗДБХ-ҮЦХОУБ нь Санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн зарчимд СЗЗДБ-ийн цахим аюулгүй байдлыг сайжруулахтай холбоотой зөвлөмжийг (Хавсралт 4) нэмэлтээр оруулж өгсөн.

37. **Бага дүнтэй, олон тооны гүйлгээ боловсруулдаг жижиглэнгийн төлбөрийн систем нь аливаа улсын эдийн засгийг төлбөрийн урсгалын гол сувгаар хангаж өгдөг.** Жижиглэнгийн төлбөрийн системийн жишээ дурдвал иргэн, аж ахуйн нэгж, Засгийн газрын гүйлгээ дамжуулах зориулалт бүхий автомат клирингийн төвүүд (ACHs), төлбөрийн картын свитчүүд багтана. Эдийн засаг, харилцагчдын хувьд жижиглэнгийн төлбөр тооцоо нь түргэн шуурхай, хямд зардлаар хүртээмжтэй, аюулгүй, хэрэглэгчийн хэрэгцээг хангах төрөл бүрийн төлбөрийн хэрэгслийг санал болгодог байх явдал хамгийн чухал байдаг. Иргэд, аж ахуйн нэгжийн хүлээлт сүүлийн жилүүдэд өөрчлөгдөж, агиин зуурын, 24/7 үйлчилгээ авах сонирхолтой болсон. Харилцагчдын хүлээлт, эрэлт хэрэгцээнд нийцүүлэн илүү шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээ бий болохын хэрээр төлбөрийн системийн дэд бүтэц үүнтэй зэрэгцэн хөгжиж, аюулгүй, тасралтгүй, найдвартай ажиллагааг ханган ажиллах шаардлагатай.

38. **Аливаа улсын санхүүгийн салбарын нэг чухал хэсэг нь үнэт цаасны зах зээл юм.** Үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламж зэрэг үнэт цаасны зах зээлийн дэд бүтцүүд найдвартай, үр ашигтай ажиллах нь төлбөр болон бусад зорилгоор барьцаа хөрөнгө байршуулах, бүс нутгийн интеграцчлалын гол элемент юм. Үнэт цаасны төлбөр тооцооны систем (ҮЦТТС), Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв (ҮЦТХТ) нь төлбөрийн системийн нэгэн адил ТЗЗДБХ-ҮЦХОУБ-ын СЗЗДБЗ-уудыг мөрдөж ажиллах ёстой. Түүнчлэн ҮЦТТС болон төлбөрийн систем хоорондоо харилцан хамааралтай байдаг. Үнэт цаасны зах зээлийн хөгжил нь мөнгөн хөрөнгө шилжүүлэх үр ашигтай, найдвартай дэд бүтцээс хамаардаг бол төлбөрийн системд санхүүжилтийн зорилгоор барьцаа хөрөнгө ашиглахад үнэт цаасны төлбөр тооцооны дэд бүтэц амин чухал юм. Үүнтэй холбоотойгоор, үнэт цаасны зохицуулагч байгууллага, төлбөрийн систем, төлбөр тооцооны банкуудын зохицуулагч болох төв банк хоорондын хамтын ажиллагаа нь эдгээр байгууллагууд хуулийн хүрээнд өөрийн бүрэн эрхээ хэрэгжүүлэх, бодлогын зорилгод хүрэхэд чухал ач холбогдолтой.

39. **Валют арилжааны зах зээлийг үр ашигтай ажиллуулахад дотоод болон гадаад валютаар арилжаа хийх, клиринг болон төлбөр тооцоо хийх найдвартай, үр ашигтай механизмтай байх шаардлагатай.** Үр ашигтай валют арилжааны зах зээл нь оролцогчид тус тусын валютаар төлбөр түргэн гүйцэтгэх чадвараа удирдах боломжийг олгож, бодит эдийн засаг, хил дамнан арилжааг дэмждэг. Төлбөрийн эсрэг нийлүүлэлт (ТЭН) болон Төлбөрийн эсрэг

төлбөр (ТэТ) гэсэн төлбөр тооцооны зохицуулалтууд нь эрсдэлийн удирдлагын гол хүчин зүйлс бөгөөд хөрөнгийн болон валют арилжааны зах зээлийн төлбөр тооцооны эрсдэлийг ихээхэн хэмжээгээр бууруулдаг.


## Монгол Улс дахь төлөв байдал

### Төлбөрийн систем

40. Монгол улсын төлбөрийн системийн гол дэд бүтэц болох их дүнтэй төлбөр тооцооны Банксүлжээ системийг 2009 онд байгуулж, ҮТС-ийг 2015-2020 оны хөгжүүлэх стратегийн хүрээнд Банксүлжээ системийн дараагийн үеийг 2018 онд нэвтрүүлсэн. Банксүлжээ системээр Монголбанк, арилжааны банкууд, Хөгжлийн банк, Сангийн яамны Төрийн сангийн газар, Монголын үнэт цаасны клирингийн төв, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв (ҮЦГХТ) гэсэн оролцогчдын гурван сая төгрөгөөс дээш дүнтэй гүйлгээг боловсруулж, дамжуулдаг. Тус систем нь өөрийн оролцогчдод төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг үр ашигтай удирдах хэд хэдэн хэрэгслийг санал болгодогос жишээ дурдвал төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хадгалах механизм, оролцогчид өөрийн дансны үлдэгдлийг онлайн аар хянах, өдрийн зээл олгох, жижиглэнгийн төлбөрийн системийн төлбөр тооцоонд зориулж хөрөнгө нөөцлөх зэрэг юм. Монголбанк нь Банксүлжээ системийн оролцогчдын төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангуулах үүднээс ТБҮЦ барьцаалсан өдрийн зээл олгодог. Банксүлжээ систем нь гүйлгээний мессежийн олон улсын шинэ стандарт болох ISO20022 стандартыг ашигладаг.

41. Банксүлжээ системээр 2020 онд ДНБ-ээс 9 дахин их буюу нийт 335.5 их наяд төгрөгийн (ойролцоогоор 119.2 тэрбум ам. доллар<sup>4</sup>) 1.6 сая гүйлгээ дамжсан байна. Түүнчлэн Банксүлжээ, АСН+ системээр 2020 онд дамжсан банк хоорондын гүйлгээний тоо өмнөх онтой харьцуулахад 45.9 хувиар, гүйлгээний дүн 14.2 хувиар тус тус өсжээ.<sup>5</sup>

### Зураг 2 Банксүлжээ системээр дамжсан гүйлгээний тоо, дүн, 2019-2020



Эх сурвалж: Монголбанк.

42. Монголбанк Банксүлжээ систем дэх оролцогчдын төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангуулах зорилгоор ТБҮЦ барьцаалан өдрийн зээл олгодог. Монголбанкны мөнгөний зах

<sup>4</sup> Энэхүү тайланд ашигласан албан ёсны ханш нь 2,813.29 (2020) байв. Эх сурвалж: Дэлхийн банк. <https://data.worldbank.org/indicator/PA.NUS.FCRF?locations=MN>

<sup>5</sup> Эх сурвалж: Монголбанкны 2020 оны жилийн ажлын тайлан.

зээлийн арилжааны платформуор дамжуулан зээлийн хүсэлтийг хүлээн авч 30 минутын дотор зөвшөөрөл олгох ба өдрийн эцэст тухайн оролцогчийн данснаас эргэн төлөлтийн гүйлгээг автоматаар хийнэ. 2020 оны хувьд банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадвар өндөр байсан тул өдрийн зээл олгогдоогүй байна.

**43. ҮТС-ийг 2015-2020 онд хөгжүүлэх стратегийн хүрээнд Монгол Улсын жижиглэнгийн төлбөрийн системийн үр ашиг, үйл ажиллагааг сайжруулах ажлууд хийгдсэн.** Монголбанкны Үндэсний цахим гүйлгээний төв (ҮЦГТ) уламжлалт АСН болон бодит цагийн бага дүнтэй гүйлгээний системийг хослуулсан орчин үеийн шинэ автоматжуулсан клирингийн төв (АСН+)-ийн системийг үйл ажиллагаандаа нэвтрүүлээд байна. Энэхүү систем нь бага дүнтэй гүйлгээг нэг бүрчлэн бодит цагийн горимоор 24/7 хуваарийн дагуу, эсвэл багцын гүйлгээ хэлбэрээр боловсруулж дамжуулдаг. Бодит цагийн горимоор гүйлгээ дамжуулах үед хүлээн авагчийн дансанд мөнгөн хөрөнгө тэр даруй орно. Олон талт үр дүнгийн тооцооллын зарчмаар клиринг хийгдэж, эцсийн төлбөр тооцоо нь тухайн гүйлгээний төлбөр тооцооны мөчлөгөөс хамаарч тэр өдрөө эсвэл дараагийн өдөр нь Банксүлжээ системээр хийгддэг. АСН+ системээр 2020 онд 14.9 их наяд төгрөгийн (ойролцоогоор 5.3 тэрбум ам. доллар) 63 сая бодит цагийн гүйлгээ (насанд хүрсэн нэг хүнд ногдох гүйлгээний тоо 28 ширхэг) хийгдсэн ба нэг гүйлгээ дунджаар 235 мянган төгрөг (ойролцоогоор 83.7 ам. доллар) байв. Мөн онд нийт 2.3 их наяд төгрөгийн 23.5 сая багцын гүйлгээ хийгдсэн байна.<sup>6</sup>

**44. ҮЦГТ-ийн ажиллуулдаг Картын нэгдсэн сүлжээ (КНС) нь төлбөрийн шинэлэг шийдэл, банк хоорондын картын нэмэлт гүйлгээ боловсруулах боломж бүхий шинэ систем нэвтрүүлээд байна.** Тус систем нь өөрийн оролцогчдын картын гүйлгээг дамжуулдаг бол, 6 банк Худалдаа хөгжлийн банк (ХХБ)-ны картын клирингийн системийн оролцогч болж, картын үйл ажиллагаа эрхэлдэг. КНС болон ХХБ-ны картын клирингийн системүүд олон талт үр дүнгийн тооцооллын зарчмаар клиринг хийж, дараагийн ажлын өдөр Банксүлжээ системээр эцсийн төлбөр тооцоо нь хийгддэг. Монголбанк ухаалаг гар утсанд суурилсан төлбөрийн картын гүйлгээ, токенжуулах үйлчилгээг нэвтрүүлж, банк болон бусад санхүүгийн байгууллагуудад зориулсан мобайл банк, токен үйлчилгээг нэвтрүүлэхээр төлөвлөөд байна. Энэхүү шинэ үйлчилгээ нь залилангийн гүйлгээ, үйлчилгээний зардлыг бууруулж, харилцагчдад төлбөр тооцоогоо зайнаас, түргэн шуурхай хийх боломжийг олгох юм. КНС-ээр 2020 онд нийт 6.9 их наяд төгрөгийн (ойролцоогоор 2.4 тэрбум ам. доллар) 249 сая гүйлгээ (насанд хүрсэн нэг хүнд ногдох гүйлгээ 110.2 ширхэг) хийгдсэн бөгөөд гүйлгээний дундаж дүн 27,627 төгрөг (ойролцоогоор 9.8 ам. доллар) байв. Мөн онд ХХБ-ны картын клирингийн системээр нийт 2.7 их наяд төгрөгийн (ойролцоогоор 1 тэрбум ам. доллар) 68.1 сая гүйлгээ хийгдсэн бөгөөд гүйлгээний дундаж дүн 39,530 төгрөг (ойролцоогоор 14.1 ам.доллар) байжээ. Карт эзэмшигчийн тоо болон гүйлгээний тоо, дүн жил бүр тогтмол өссөн үзүүлэлттэй байна.

**45. Монголбанк нь төлбөрийн системийн оролцогчидтой (банк болон банк бус) нягт хамтран ажилладаг боловч Монголбанкны ажиллуулж буй төлбөрийн системд зориулсан албан ёсны Хэрэглэгчдийн групп үүсгээгүй байна.** Хэрэглэгчдийн групп нь системийн оролцогчид хооронд болон системийн оператор, оролцогчийн хооронд (i) системийн үйл ажиллагаатай холбоотой үүсэж буй аливаа асуудал; (ii) ирээдүйн хөгжил, системийн шинэчлэлийн асуудлаар тогтмол хэлэлцүүлэг өрнүүлэх, мэдээлэл солилцох боломж олгодог давуу талтай.

**46. Монгол Улс бэлэн мөнгөний хэрэглээ багатай эдийн засаг руу шилжихийн хэрээр шинэ сорилт, эрсдэлүүд гарч ирж байгаагийн дотор төлбөрийн системийн дэд бүтцийн цахим аюулгүй байдлыг хангах явдал нэн тулгамдаж буй асуудал юм.** Сүүлийн 10 жилийн

---

<sup>6</sup> Эх сурвалж: Монголбанк

хугацаанд дэлхий даяар цахим халдлагын тоо гурав дахин нэмэгдэж цахим эрсдэл анхаарал татсан асуудал болоод байна.<sup>7</sup> Санхүүгийн системүүд нэг ижил сүлжээ, технологийн дэд бүтцээс хамааралтай байдаг тул эдгээр халдлага нь санхүүгийн тогтвортой байдалд заналхийлж болзошгүй юм. Банксүлжээ, АСН+ зэрэг үндсэн систем рүү амжилттай халдлага хийснээр санхүүгийн систем даяар хурдацтай тархаж, өргөн хүрээг хамарсан тасалдал, саатал, томоохон хохирол учруулж, санхүүгийн системд итгэх олон нийтийн итгэлийг алдахад хүргэх юм. Иймд банк хоорондын үндсэн системүүдийн цахим аюулгүй байдлыг хангах нь эрх бүхий байгууллагуудын нэн тэргүүний зорилтуудын нэг болж байна.

**47. Түүнчлэн, систем болон тэдгээрийн оролцогчдод үйл ажиллагааны тасралтгүй байдлын төлөвлөгөө, зохицуулалт байх нь маш чухал.** Дэлхий нийтийг хамарсан КОВИД-19 цар тахал нь гэнэтийн, урьдчилан таамаглаагүй үйл явдлаас шалтгаалж томоохон сорилт, бэрхшээл гарч болохыг, мөн үүнд бэлэн байхын тулд урьдчилан төлөвлөх шаардлагатайг харууллаа. Дэд бүтцийг сайжруулж, техникийн шинэлэг боломжийг бүрдүүлэх зорилгоор төлбөрийн системийн үндсэн болон нөөц дата төвүүдийг шинэчлээд байна. Дата төвийн шинэчлэл нь төлбөрийн системийн тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах чухал алхам болсон юм.

**1 дүгээр хүснэгт. Монгол Улсын төлбөр тооцооны дэд бүтцээр дамжин хийгдсэн гүйлгээний тоо ба дүн (2020)**

	Гүйлгээний тоо (саяар)	Гүйлгээний дүн (их наяд төг)	Нэг хүнд ногдох гүйлгээний тоо	Нэгж гүйлгээний дундаж дүн
<i>Банксүлжээ систем</i>	1.6	335.5 (119.2 тэрбум ам.доллар)	-	213 сая төг ( 75,715.8 ам.доллар)
<i>АСН+ (Бодит цагийн гүйлгээ)</i>	63.2	14.9 (5.3 тэрбум ам.доллар)	28	235,000 төг (83.7 ам.доллар)
<i>АСН+ багцын гүйлгээ</i>	23.5	2.3		100,000 төг
<i>Картын нэгдсэн сүлжээ</i>	249	6.9 (2.4 тэрбум ам.доллар)	110.2	27,627 төг (9.8 ам.доллар)
<i>ХХБ-ны картын клирингийн систем</i>	68.1	2.7 (1 тэрбум ам.доллар)	30.1	39,530 төг (14.1 ам.доллар)
<i>Нийт</i>	405.4	362.3	-	-

**Үнэт цаасны төлбөр тооцооны систем**

**48. Монгол Улсын үнэт цаасны зах зээл хөгжиж байгаа хэдий ч харьцангуй жижиг хэвээр байна.** Үнэт цаасны зах зээл дээр арилжаалагдаж буй үндсэн бүтээгдэхүүн нь Засгийн газрын

<sup>7</sup> Олон улсын валютын сан: <https://blogs.imf.org/2020/12/07/cyber-risk-is-the-new-threat-to-financial-stability/>

үнэт цаас, Төв банкны үнэт цаас (ТБҮЦ), хувьцаа, компанийн бонд байна. Монголын хөрөнгийн бирж (МХБ) дээр хувьцаа болон компанийн бонд арилжаалагддаг бол Засгийн газрын үнэт цаасыг МХБ, эсхүл Монголбанкны онлайн арилжааны платформуур дамжуулан хоёрдогч зах зээлд гаргаж, арилжаалах боломжтой. Энэхүү платформыг мөн ТБҮЦ, валютын арилжаанд ашигладаг. Монгол Улсын Засгийн газар 2017 оны 11 дүгээр сараас эхлэн Засгийн газрын үнэт цаас гаргахаа зогсоосон бөгөөд одоогоор зөвхөн 10 жилийн хугацаатай үнэт цаасыг хоёрдогч зах зээл дээр арилжаалах боломжтой байгаа ч банкууд 2019 оны эхнээс хойш энэ төрлийн арилжаа хийгээгүй байна. 2021 оны 9 дүгээр сарын 30-ны байдлаар нээлттэй зах зээл дээрх үнэт цаасны хэмжээ ердөө 22.5 тэрбум төгрөг болж буурчээ<sup>8</sup>. 2020 онд МХБ-д бүртгэлтэй үнэт цаасны зах зээлийн үнэлгээ гурван их наяд орчим төгрөг (ДНБ-ий 8.1%) болсон байна.<sup>9</sup>

**49. Үнэт цаасны зах зээлийн клиринг болон төлбөр тооцооны дэд бүтцийг бий болгож, хууль эрх зүйн зохицуулалтын тогтолцоог боловсронгуй болгож байна.** Монголбанк нь ТБҮЦ-ны хувьд ҮЦТХТ болон ҮЦТТС-ийн үүрэг гүйцэтгэдэг бөгөөд ТБҮЦ-ны төлбөр тооцоо, хадгаламжийн системийг Банксүлжээ систем, Монголбанкны онлайн арилжааны платформтой нэгтгэх ажлыг хийж гүйцэтгээд байна. ТБҮЦ-ны гүйлгээ, өдрийн зээл олгохтой холбоотой гүйлгээний төлбөр тооцоо ТЭН зарчмаар хийгддэг хэдий ч нийт үйл явц нь бүрэн автоматжаагүй байна.

**50. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв (ҮЦТХТ) хувьцаа, компанийн бонд, Засгийн газрын үнэт цаасны бүртгэлийг хөтөлж, хадгалдаг.** Монголын Үнэт цаасны клирингийн төв (МҮЦКТ) нь МХБ-ээр хийгдэж буй бүх хэлцлийн төлбөр тооцоо, түүнчлэн Засгийн газрын үнэт цаасны биржийн гадуурх арилжааны төлбөр тооцоог хийж гүйцэтгэдэг. МХБ-д арилжаалагдаж буй үнэт цаасны хөрөнгийн төлбөр тооцоо ТЭН зарчмаар дөрвөн Төлбөр тооцооны банкаар дамжуулан хийгддэг. МХБ, МҮЦТХТ, МҮЦКТ нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн дагуу Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)-ны хяналт зохицуулалтад байдаг төрийн өмчит аж ахуйн нэгж бөгөөд өмчлөлийн эрхийг нь СЯ хэрэгжүүлдэг.<sup>10</sup> МҮЦТХТ болон МҮЦКТ-ийн ТЗЗДБХ-ҮЦХОУБ-ын СЗЗДБЗ-д нийцсэн эсэх үнэлгээг одоогоор хийгээгүй байна.

#### ***Валютын арилжааны төлбөр тооцоо***

**51. Банк хоорондын валютын арилжааны зах зээлийн хөгжлийг дэмжих зорилгоор Монголбанк 2018 онд гадаад валютын онлайн арилжааны системийг нэвтрүүлсэн.** Шинэ систем нь дотооддоо боловсруулсан программ хангамжид суурилсан бөгөөд арилжааны үйл явцыг хялбарчилж өгсөн. Валютын онлайн арилжааны системийг арилжааны банкууд өөрсдийн бизнесийн харилцагчид болон иргэдэд зориулан өөр хоорондоо, мөн Монголбанктай гадаад валютын (ихэвчлэн ам.доллар, юань) арилжаа хийхэд ашигладаг. Арилжааны банкууд Монголбанканд ам.доллар, юань, евро, иенийн данс хөтөлж, түүгээр дамжуулан гадаад валютын төлбөр тооцоог гүйцэтгэдэг бол төгрөгийн төлбөр тооцоо нь Банксүлжээ систем дээр хийгддэг. Төлбөр тооцоо нь ТЭТ зарчмын дагуу явагддаг тул оролцогч талын буюу төлбөр тооцооны эрсдэлийг арилгадаг. Мөн банкууд бусад банкин дээр нээсэн дансаа ашиглан онлайн арилжааны системээс гадуур валют арилжаалах боломжтой бөгөөд энэ тохиолдолд ТЭТ зарчмын дагуу арилжаа хийгдэхгүй байх боломжтой.

<sup>8</sup> Эх сурвалж: Монголбанкны 2020 оны жилийн тайлан.

<sup>9</sup> Эх сурвалж: СЗХ, Монголбанк

<sup>10</sup> Хоёрдахь хөрөнгийн бирж болох "Монголын үнэт цаасны бирж" (МҮЦБ) нь 2015 онд байгуулагдаж, 2017 онд анхны үнэт цаасаа бүртгэсэн. Энэ нь үнэт цаасны арилжаа, клирингийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй, СЗХ-ноос зохицуулалттай, хувийн өмчит бирж юм. 2019 оны 12 дугаар сарын байдлаар МҮЦБ дээр 2.5 тэрбум төгрөгийн зах зээлийн үнэлгээтэй нэг компани, нэг компанийн өрийн үнэт цаас бүртгэлтэй байв. Эх сурвалж: Монголын бондын зах зээлийн гарын авлага, 2021, Азийн хөгжлийн банк.

**52. Монголбанкны мөнгөний зах зээлийн үйл ажиллагаанд мөн дээрх онлайн арилжааны системийг ашигладаг.** Гол хэрэгсэл нь ТБҮЦ-ны репо арилжаа, овернайт зээл, арилжааны банкууд хооронд болон банкууд, Монголбанк хоорондын хадгаламж юм. Энэхүү арилжааны платформд зөвхөн банкууд, Хөгжлийн банк, Хадгаламжийн даатгалын корпораци нэвтрэх эрхтэй.

53. Монголбанк ҮТС-ийг 2015-2020 онд хөгжүүлэх стратегийн дагуу мөнгөний зах зээл, валютын арилжаа, ҮЦТТС болон ҮЦТХТ-ийн системийн аюулгүй байдал, үр ашиг, эрсдэлийн удирдлагыг бэхжүүлэх, ТЭН болон ТЭТ зарчмуудад суурилсан олон талт төлбөр тооцоог ашиглах зорилгоор Банксүлжээ системтэй уялдаатай ажиллах арилжааны платформыг боловсруулж, 2022 онд бүрэн нэвтрүүлэх зорилго тавин ажиллаж байна.

### **Зорилго ба гол арга хэмжээ**

#### **Зорилго # 5: ҮТС-ийн үр ашигтай, аюулгүй, найдвартай, тасралтгүй үйл ажиллагааг хангах**

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа 1.** Монголбанк Банксүлжээ систем, жижиглэнгийн төлбөрийн системүүдийн операторын хувьд Эрсдэлийн удирдлагын цогц баримт бичгийг боловсруулж, эрсдэлийн гол үзүүлэлтүүдийг тогтмол хянах;

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа 2.** Монголбанк өөрийн хариуцан ажиллуулдаг системүүдийн цахим аюулгүй байдлын эрсдэлийг удирдах, хянах, бууруулах зорилгоор үнэлгээ хийж, стратеги төлөвлөгөө боловсруулан, хүний нөөцийн мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх. Монголбанк цахим аюулгүй байдлын олон улсын стандартыг төлбөрийн системд нэвтрүүлэх;

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа 3.** Монголбанк өөрийн хариуцан ажиллуулдаг системүүд болон оролцогчдод зориулсан, цар тахал болон гамшгийн төрөл бүрийн болзошгүй нөхцөлүүдийг хамруулсан Тасралтгүй ажиллагааны төлөвлөгөөг тогтмол шинэчлэх. Монголбанкнаас системийн аливаа саатлын дараах нөхөн сэргээх хугацаа, зорилтыг тодорхой болгож, албажуулах;

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа 4.** Банксүлжээ систем, АСН+, Картын нэгдсэн сүлжээтэй холбоотой мэдээлэл солилцох, санал хүсэлтэд хариу зорилгоор Хэрэглэгчдийн группийг албан ёсоор байгуулах;

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа 5.** Банксүлжээ системийн оролцогчдын төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангуулах зорилгоор өдрийн зээл олгох үйл явцыг бүрэн автоматжуулах. Зөвшөөрөгдсөн барьцаа хөрөнгийг үндэслэн оролцогч талуудад өдрийн зээлийг шууд олгох;

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа 6.** Валютын арилжааны төлбөр тооцооны эрсдэлийг үнэлэх зорилгоор өөрийн цахим арилжааны системээс гадуурх валютын арилжааны гүйлгээний төлбөр тооцооны зохицуулалт, дотоодын зах зээл болон хил дамнасан гадаад валютын гүйлгээний урсгал, корреспондент банкны харилцаанд дүн шинжилгээ хийх.

#### **Зорилго # 6: ҮЦТТС болон ҮЦТХТ-ийн үйл ажиллагаанд Санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн зарчмыг мөрдөх**

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа 1.** Монголбанк СЗХ-г МҮЦТХТ, МҮЦКС-ийг Санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн зарчмын дагуу мөнгөн хөрөнгийн клиринг, төлбөр тооцоотой хамааралтай хэсгийн үнэлгээ хийхэд хамтран ажиллах.

### 3.11 Стратегийн III бүрэлдэхүүн хэсэг: Цахим төлбөрийн хэрэгсэл, үйлчилгээг бүх нийтээр ашиглах

#### 3.11.1 Төлбөрийн хэрэгслүүд ба үйлчилгээ

##### Нөхцөл байдал

54. **Төлбөр гүйцэтгэх арга үндсээрээ өөрчлөгдөж, бэлэн мөнгө, цаасанд суурилсан хэрэгслээс цахим төлбөрийн арга руу шилжиж байна.** Технологийн шинэчлэл, шинэ төрлийн төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчид болон зан төлөвийн өөрчлөлтөөс үүдэлтэй энэхүү шилжилт нь харилцагчид, бизнес эрхлэгчдэд төлбөр төлөх төрөл бүрийн аргууд, хүртээмж, зардал хэмнэх боломжийг олгосноор эдийн засагт бүхэлд нь үр өгөөжөө өгдөг байна.

55. **Гэсэн хэдий ч шинэлэг төлбөрийн хэрэгслүүд шинэ сорилтуудыг үүсгэж байна.** Аливаа гүйлгээ хийх үед түүний нууцлал, аюулгүй байдал гол асуудал болсон бөгөөд төлбөр хийж буй хэрэглэгч, байгууллагууд нууцлал, аюулгүй байдлыг хангаж, хэрэглэгчийн хувийн мэдээллийг хамгаалсан төлбөрийн үйлчилгээ, хэрэгслийг илүүд үзэх болсон. Санхүүгийн үйлчилгээ цахимжсанаар зах зээлийн өрсөлдөөнийг дэмжин, байгууллагууд, төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчид болон зохицуулагчид нээлттэй банкны стратеги, API дэмждэг мэдээллийн технологийн архитектур ашиглаж эхлэхэд нөлөөлсөн. Нээлттэй банк ашиглах үед хэрэглэгчийн мэдээлэл солилцох шаардлагатай болдог тул өгөгдлийн нууцлал, аюулгүй байдал, хамгаалалт нэн тэргүүний асуудал юм. Түүнчлэн жижиглэнгийн төлбөр тооцоо, үйлчилгээний хувьд цахим төлбөр, үйлчилгээний талаарх хэрэглэгчдийн мэдлэгийг дээшлүүлэх, хэрэглэгчийг хамгаалах арга хэрэгслийг бий болгох нь чухал ач холбогдолтой. Зах зээлийн интеграцлал, нэгдмэл байдал, стандартчилал нь жижиглэнгийн гүйлгээний зах зээлийн үр ашгийг нэмэгдүүлэхэд гол үүрэг гүйцэтгэдэг. Улс орнуудын жижиглэнгийн төлбөрийн системийн шинэчлэл, цахим төлбөрийн хэрэгсэлд шилжих шилжилтэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Дэлхийн банк жижиглэнгийн төлбөрийн системийн стратеги боловсруулах аргачлал боловсруулаад байна (Хавсралт 5).

56. **Төв банкууд болон бусад зохицуулагч байгууллагууд инноваци дэмжих төрөл бүрийн арга хэрэгслийг ашиглан цахимжуулалт хийх, инноваци нэвтрүүлэх хувийн хэвшлийн санаачилгыг дэмжин ажиллаж байна.** Инновац дэмжих арга хэрэгслийн хамрах хүрээ, зорилго нь янз бүр байж болох бөгөөд инновацийг нэвтрүүлэхэд учирч байгаа саад бэрхшээлийг ярилцах, санхүүгийн дэмжлэг үзүүлэх, туршилтын шатанд зохицуулалтын зарим шаардлагыг хөнгөлөх зэргээр дэмжлэг үзүүлж болдог. Инновац дэмжих аргуудаас жишээ дурдвал инновацийн төв, инновацийн оффис, сэндбокс зэрэг байна.

##### Монгол Улсын төлөв байдал


57. **КОВИД-19 цар тахлын нөлөөгөөр Монгол Улсад цахим төлбөрийн хэрэглээ огцом нэмэгдсэн.** Сүүлийн нэг жилийн хугацаанд ихэнх төлбөр тооцоо бэлэн мөнгөнөөс цахим хэлбэр рүү шилжсэн. 2020 онд төлбөрийн картын хэрэглээ нэмэгдээд зогсохгүй нийт картын гүйлгээний тоон мэдээг харахад АТМ-аас бэлэн мөнгө авах гүйлгээ буурч, төрөл бүрийн сувгаар хийгдсэн цахим төлбөрийн гүйлгээний тоо нэмэгдсэн байна.<sup>11</sup> Энэ нь Монгол Улс жижиглэнгийн төлбөр тооцооны найдвартай дэд бүтэц, үйлчилгээг хөгжүүлж чадсан бөгөөд өнөөг хүртэл хэрэгжүүлсэн шинэчлэлийн үр шимийг хүртэж байгааг харуулж байна. Цаашид энэхүү цар тахлын үед гарсан ахиц дэвшилд дөрөөлөн, Монгол Улсыг бүх нийтээрээ цахим төлбөр тооцоог ашигладаг болох замд оруулах шаардлагатай юм.

<sup>11</sup> Эх сурвалж: Монголбанк

58. 2017 оны байдлаар Монгол Улсын насанд хүрсэн нийт хүн амын 93 хувь нь санхүүгийн байгууллагад данстай болсноор бараг бүх нийтээрээ данс ашигладаг болсон байна.<sup>12</sup> 2017 онд иргэдийн 85 гаруй хувь нь цахимаар төлбөр илгээж, хүлээн авсан, 60 хувь нь дебит эсхүл зээлийн карт ашиглан худалдан авалт хийсэн байна. Хэдий тийм ч Монгол Улсад цахим төлбөрийн хэрэгслийн хэрэглээг тэлэх, инноваци хийх томоохон орон зай байсаар байна. Тухайлбал, насанд хүрэгчдийн талаас бага хувь нь хэрэглээний төлбөрөө төлөх, 27 хувь нь цалин авах, 17 хувь нь онлайнар хэрэглээний төлбөрөө төлөх, худалдан авалт хийхдээ данс ашиглаж байна.

59. Дебит карт нь Монголд хамгийн түгээмэл хэрэглэгддэг цахим төлбөрийн хэрэгсэл юм. Нийт картын тоо 2020 онд өмнөх онтой харьцуулахад 10.1 хувиар, 2021 оны 2 дугаар улиралд өмнөх оны мөн үеэс 10.6 хувиар тус тус өссөн байна.<sup>13</sup> 2020 онд гаргасан нийт картын ихэнх хувийг буюу 62.5 хувийг үндэсний брэнд ₮ карт эзэлж байна. Харин хэрэглээний зээлийн хязгаарлалт шинээр тогтоосон, мөн КОВИД-19 цар тахлаас шалтгаалж шинэ картын борлуулалт буурсантай холбоотойгоор гүйлгээнд гаргасан кредит картын тоо<sup>14</sup> 2019 оноос хойш буурах хандлагатай болсон бөгөөд 2020 оны эцэс гэхэд ердөө 194 мянган кредит карт хэрэглээнд байна.<sup>15</sup> ПОС терминалын тоо, тус терминалаар хийгдсэн бараа, үйлчилгээний төлбөр төлөх гүйлгээний тоо, дүн огцом өссөн. Мөн 2020 онд төлбөрийн картаар хийсэн цахим худалдааны гүйлгээ 2019 онтой харьцуулахад тоо болон дүнгийн хувьд хамгийн хурдацтай (66.9, 53.2 хувиар) өсжээ. Иргэд болон жижиг бизнесийн хувьд цахим төлбөрийн дийлэнх хувийг төлбөрийн картад суурилсан гүйлгээ эзэлж байна.

### Зураг 3 Дебит, кредит картын тоо (2019-2021)



Эх сурвалж: Монголбанк болон Дэлхийн банкны тооцоолол

60. Гар утасны аппликэйшн, интернэт банк, АТМ (АТМ-с бэлэн мөнгө авах, кредит шилжүүлэг хийх замаар хэрэглээний төлбөр төлөх зэрэг үйлчилгээг авах боломжтой) зэрэг сувгуудыг түгээмэл ашиглан төлбөр тооцоо хийж байна. Гар утасны аппликэйшн, интернэт банк ашиглан хийж буй гүйлгээ жил бүр нэмэгдэж байгаа бөгөөд 2020 онд гар утасны

<sup>12</sup> Эх сурвалж: Дэлхийн банкны Глобал Финдекс, 2017


<sup>13</sup> Эх сурвалж: Монголбанк

<sup>14</sup> Дараахи 3 төрлийн зээлийн карт ашиглаж байна. Үүнд: Дотоодын брэндийн төгрөгийн карт, олон улсын брэндийн карт болон хосолсон брэндийн (дотоод + олон улсын).


<sup>15</sup> Эх сурвалж: Монголбанк

аппликэйшн ашиглан хийсэн гүйлгээний тоо нийт гүйлгээний 32.2 хувийг эзэлж байсан бол интернэт ашиглан хийгдсэн гүйлгээ нь нийт гүйлгээний үнийн дүнгийн 80 орчим хувийг эзэлжээ. (Зураг 5).

**Зураг 4. Гүйлгээний тоо, хандалтын сувгаар, 2019-2020**



Эх сурвалж: Монголбанк



61. Төлбөрийн картын гүйлгээний найдвартай, үр ашигтай, аюулгүй байдлыг сайжруулахын тулд Монголбанк хэд хэдэн арга хэмжээ авч хэрэгжүүлсний нэг нь картын гүйлгээний луйврыг бууруулах зорилгоор Үндэсний брэнд ₮ картыг олон улсын **EMV чипийн стандартад** шилжүүлэх бэлтгэл ажил дуусаж, банкууд EMV чип бүхий үндэсний брэнд ₮ картыг 2021 оны 10 дугаар сараас олгож эхлээд байна. ₮ картыг бүрэн чипжүүлэх ажил 2024 он хүртэл үргэлжилнэ. Түүнчлэн, дотоодын картууд зайнаас унших NFC технологитой болж байгаа нь КОВИД-19 цар тахлын үеэр төлбөр тооцоо хийхэд учирч байсан хүндрэлийг арилгах цаг үеэ олсон алхам болж байна. Монголбанк 2020 он чиптэй картаар ПИН код ашиглалгүй хийх гүйлгээний хязгаарыг 100,000 төгрөг болгон нэмэгдүүлсэн. Мөн онлайн худалдан авалтын гүйлгээг зөвхөн интернэт ПИН кодоор баталгаажуулдаг байсныг халж, карт хүлээн авагчийн сонголтоор ПИН код эсвэл CVV код ашиглан баталгаажуулах боломжийг нээгээд байна.

**62. Монголбанкны зүгээс Олон улсын банкны дансны дугаарлалт (IBAN)-тай холбоотой заавар гарган, Монгол Улсын банкны дансны дугаарлалтыг стандартчилах ажлыг эхлүүлээд байна.** Тус зааврыг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар 2020 оны 3 дугаар сард баталсан бөгөөд банкууд 2022 оноос эхлэн стандарт хангасан дансны дугаар олгох, хөрвүүлэх ажлыг эхлүүлэх, 2024 он гэхэд бүрэн шилжиж дуусахаар төлөвлөн ажиллаж байна.

**63. Олон банк өөрсдийн гар утасны аппликэйшнаар дамжуулан QR код уншуулж худалдаа үйлчилгээний байгууллагад төлбөр хийх боломжийг хэрэглэгчдэд олгож эхлэв.** Монголд QR код стандартчилагдаагүй тул банк, төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нар өөр өөр төрлийн QR код ашиглах, худалдаа үйлчилгээний байгууллага дээр олон код байршуулах асуудал гарч байна. Гэвч QR код ашиглан хийх гүйлгээний тоо дүн тогтмол өсөж байгаа бөгөөд 2019 онд 3.8 сая гүйлгээ хийгдсэн бол 2020 онд энэ нь 3 дахин өсөж 11.3 сая гүйлгээ хийгджээ. QR код ашигласан төлбөр тооцоо 2021 оны 3 дугаар улирлын эцсийн байдлаар 21.3 саяд хүрсэн байна.

**64. Монголын төлбөрийн зах зээлд банкууд давамгайлж байгаа хэдий ч, Финтекууд олон төрлийн үйлчилгээг санал болгож байна.** Зарим компани хэтэвчний үйлчилгээ гарган, худалдаа үйлчилгээний байгууллагад төлбөр төлөх, шилжүүлэг хийх, онлайн худалдан авалт хийх боломжтой хэрэглэгчид чиглэсэн шийдлүүдийг гаргаж байгаа бол хиймэл оюун ухаан ашиглан зээлжих зэрэглэлийг тогтоох, бичил болон жижиг зээл олгох үйлчилгээ, өөрийн олон банкны дансыг холбон удирдах, төлбөр төлөх боломжтой “гүйлгээ эхлүүлэх” үйлчилгээ эрхлэгч компаниуд ч гарч ирээд байна. Гэсэн хэдий ч төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч финтек компани харьцангуй цөөн хэвээр байна.

**65. Банк, банк бус төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нарын хувьд олон улсын жишгээр хэрэглээний програмчлалын интерфейс буюу API ашиглах явдал түгээмэл болж байна.** Үйлчилгээ үзүүлэгч нар хэрэглэгчдээ нэмэлт, шинэ төрлийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор API ашиглан бусад төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчид, хөгжүүлэгчид зэрэг гуравдагч талуудтай өөрт байгаа өгөгдлийг автоматаар хуваалцах боломжтой. Олон байгууллагууд өөр өөрсдийн API-г боловсруулж, ашиглаж байгаа ч Монголд одоогоор API-н нэгдсэн стандарт байхгүй, нээлттэй банк ашиглах хууль эрх зүйн орчин бүрдээгүй байна.

**66. Монголбанк төлбөрийн систем дэх инноваци, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг дэмжих төрөл бүрийн арга хэрэгсэл ашиглаж байна.** Монголбанк стандартчилал, нэгдмэл байдлыг хангах, төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нарын тэгш тэнцвэртэй оролцоог хангах зэргээр зохицуулалтын арга хэмжээ авахын сацуу төлбөрийн шинэлэг шийдэл, үйлчилгээг цаашид дэмжих олон улсын туршлагаас авч хэрэгжүүлж байна. Жишээлбэл бусад орны төв банкуудын жишгээр инновацийн оффис байгуулах, СЗХ, Сангийн яамтай хамтран сэндрбокс нэвтрүүлэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

**67. Гүйлгээний хураамж шимтгэл харьцангуй өндөр байгаагаас цахим төлбөрийн үйлчилгээг бүх нийтээр хэрэглэхэд саад болж байгааг албан бус баримт нотолгоо харуулж байна.** Хэдийгээр тодорхой тоон мэдээлэл байхгүй ч, зарим оролцогч талууд банк хоорондын гүйлгээний өртөг зардал өндөр байгаагаас ийм төрлийн үйлчилгээг нэвтрүүлэх, өргөнөөр хэрэглэхэд саад болж байна гэж үзэж байна. Үйлчилгээний шимтгэл хураамжийг үзүүлж буй үйлчилгээний зардалтай уялдаатай тогтоосон эсэхийг тогтоож, үйлчилгээ үзүүлэгчдэд учирдаг зардлын дарамтыг бууруулах шаардлагатай байна. Цаашлаад цахим төлбөр тооцоог өргөнөөр хэрэглэхэд учирч буй аливаа саад бэрхшээлийг олж тогтоон, шаардлагатай арга хэмжээг авах нь чухал юм.

**Зорилго ба гол хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

**Зорилго # 7: Инноваци, цахим төлбөрийн хэрэглээг нэмэгдүүлэх**

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа 1.** Төлбөрийн зах зээл дэх инновацийг дэмжиж, зах зээлд төлбөрийн шинэ шийдлүүдийг бий болгоход дэмжлэг үзүүлэх арга хэрэгслүүдийг тодорхойлж хэрэгжүүлэх;

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа 2.** Төлбөр тооцоо хийх зардал, хэрэглэгчийн зан төлөв, түүнийг өөрчлөх хүчин зүйлс зэргийг багтаасан цахим төлбөрийн хэрэглээний талаарх иж бүрэн судалгааг хийх. Судалгааны үр дүнд үндэслэн Монголбанк цахим төлбөрийн хэрэглээг нэмэгдүүлэхэд чиглэсэн шаардлагатай арга хэмжээг авах;

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа 3.** Монголбанк 2024 он гэхэд үндэсний брэнд ₮ картыг EMV чип рүү бүрэн шилжүүлэхэд банкуудтай хамтран ажиллах;

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа 4.** Төлбөрийн системийн нэгдмэл байдлыг хангах, зах зээл дэх өрсөлдөөн, инновацийг дэмжих зорилгоор төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчийн дансны дугаарлалт (IBAN), QR кодыг стандартчилах ажлыг гүйцэтгэх;

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа 5.** Төлбөрийн шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээ зах зээлд гарч ирж байгаатай холбогдуулан, Монголбанк нь зах зээлд оролцогчидтой хамтран цахим төлбөрийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, түүний хэрэглээний талаар олон нийтийн боловсролыг дээшлүүлэхэд анхаарч ажиллах.

### 3.11.2 Засгийн газрын төлбөрүүд

#### Нөхцөл байдал

**68. Засгийн газрын төлбөрийн хэмжээ, цар хүрээ, ач холбогдол нь улс орны жижиглэнгийн төлбөрийн дэд бүтцийг хөгжүүлэх, шинэчлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Засгийн газар, төрийн байгууллагууд нь татвар, цалин хөлс, нийгмийн халамж, бараа, үйлчилгээний төлбөр төлөх зэргээр гүйлгээний томоохон урсгалыг бий болгодог. Засгийн газрын төлбөр тооцоог цахимжуулах замаар иргэдэд хүрэх үйлчилгээг сайжруулж, зардлыг хэмнэж, ил тод, аюулгүй байдлыг хангаж, нийт эдийн засаг дах төлбөр тооцоог цахимжуулахад томоохон түлхэц болно. Мөн банкны үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа иргэдэд бэлэн бус цахим төлбөрийн хэрэгслийг хүргэх замаар санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх төрийн бодлогын зорилтод хүрэх үр дүнтэй хэрэгсэл юм. Засгийн газрын төлбөрийг цахимжуулах нь төв банк, төлбөр тооцооны салбар болон Засгийн газрын хамтын хүчин чармайлтаар хийгдэх цогц ажил юм.**<sup>16</sup>

#### Монгол Улсын төлөв байдал

**69. Монгол улсын Засгийн газраас иргэд, аж ахуйн нэгж рүү илгээх ихэнх төлбөр тооцоо Монголбанкны хариуцан ажиллуулдаг төлбөрийн системийн дэд бүтцээр дамжин хийгдэж байна.** Үүнд Банксүлжээ, АСН+ системээр дамжуулан банкны данс руу нь шилжүүлэх төрийн байгууллагын ажилтнуудын цалин, тэтгэвэр, нийгмийн халамж, татварын буцаан олголт, цар тахлын үеэрх мөнгөн тусламж, хүүхдийн мөнгө, аж ахуйн нэгжүүдэд төлөх төлбөр зэрэг багтана. Засгийн газар нь АСН системийн шууд оролцогч тул эдгээр гүйлгээг багцлан илгээж хүлээн авагчийн дансанд түргэн шуурхай орох боломжтой болоод байна.

**70. Татварын Ерөнхий газар нь иргэдийн бүртгүүлсэн баримтад үндэслэн НӨАТ-ын буцаалт олгох системийг хөгжүүлээд байна.** Иргэд бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан баримтаа Татварын Ерөнхий газрын хөгжүүлсэн цахим хуудас, гар утасны аппликэйшн руу бүртгүүлснээр 2 хувийн буцаан олголт авах боломжтой болсон.

<sup>16</sup> Дэлхийн банкны 2012 оны “Засгийн газрын төлбөрийн хөтөлбөр боловсруулах ерөнхий удирдамж” нь олон улсын шилдэг практик дадалд үндэслэгдсэн хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан чиглүүлэх өргөн хүрээг хамарсан суурь үндэс болж өгсөн.

71. Иргэд, аж ахуйн нэгжүүд банкны шилжүүлэг, банкны салбар дээр бэлэн мөнгөөр эсвэл интернэт банк, гар утасны аппликэйшний тусламжтай татвараа төлөх боломжтой. Хэдий тийм ч иргэнээс Засгийн газар, байгууллагаас Засгийн газар руу чиглэсэн гүйлгээ банкны салбар дээр бэлэн мөнгөөр түлхүү хийгдсээр байна.

72. Монгол Улсын Засгийн газар “E-Mongolia” цахим платформоор дамжуулан иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад үзүүлэх төрийн бүх үйлчилгээг цахимжуулж байна. “E-Mongolia” буюу Цахим Монгол хөтөлбөрийн зорилго нь иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний үр ашгийг дээшлүүлэхийн тулд төрийн үйлчилгээг нэг системд нэгтгэх явдал юм. “Цахим Монгол” хөтөлбөрийг хэрэгжүүлснээр иргэд нэг цэгийн үйлчилгээний төв болох системээс төрийн нийт 181 үйлчилгээг авах боломжтой болох юм. Энэхүү нэг цэгийн үйлчилгээний систем нь Монголбанкны одоогийн төлбөрийн системийн дэд бүтцийг ашиглан төлбөр хүлээн авна.

### Зорилго ба гол арга хэмжээ

#### ЗОРИЛГО # 8: ЗАСГИЙН ГАЗРЫН ТӨЛБӨРИЙГ ЦАХИМЖУУЛАХ АЖЛЫГ ҮРГЭЛЖЛҮҮЛЭХ

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа 1.** Цахим Монгол хөтөлбөрийг дэмжиж, E-Mongolia платформоор хийгдэж буй бүх төлбөрийг цахим хэлбэрээр тасралтгүй, үр ашигтай, аюулгүй байдлаар дамжуулах нөхцөлийг бүрдүүлэх.

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа 2.** Цахим төлбөр тооцоог дэмжиж, цахим төлбөрийн хэрэгслээр бараа бүтээгдэхүүн худалдан авсан нөхцөлд татварын системд автоматаар бүртгэгдэн, НӨАТ-ын буцаан олголт хийх талаар судлах.

#### 3.11.3 Хил дамнансан төлбөр тооцоо ба гуйвуулга

##### Нөхцөл байдал

73. Шуурхай, хямд, ил тод, хүртээмжтэй хил дамнансан төлбөрийн үйлчилгээ нь дэлхийн өнцөг булан бүрд байгаа иргэд болон эдийн засагт үр өгөөжөө өгч, эдийн засгийн өсөлт, олон улсын худалдаа, дэлхийн хөгжил, санхүүгийн хүртээмжид дэмжлэг үзүүлдэг.<sup>17</sup> Хил дамнансан жижиглэнгийн гүйлгээ нь илүү олон тоглогчид, цагийн бүс, эрх бүхий байгууллага, зохицуулалтыг хамардаг тул дотоодын төлбөр тооцоотой харьцуулахад илүү нарийн төвөгтэй байдаг. Харьцангуй цөөн буюу үе үе тохиолдлын шинжтэй гүйлгээ илгээдэг хувь хүмүүс болон жижиг бизнесүүд үйлчилгээний хүртээмж, шимтгэл хураамжид өндөр ач холбогдол өгдөг.

74. Ихэвчлэн цагаач ажилчид эх орондоо үлдсэн гэр бүлийнхэн рүүгээ мөнгө илгээхдээ ашигладаг олон улсын мөнгөн гуйвуулгын үнэ өртөг өндөр гэдгийг дэлхий даяараа мэддэг. Мөнгөн гуйвуулгын шимтгэл хураамжийг бууруулах, зах зээл дэх ил тод байдал, өрсөлдөөнийг нэмэгдүүлэх зорилго бүхий хэд хэдэн ажлууд дэлхий даяар хийгдэж байна. Үүнд, мөнгөн гуйвуулгын дэлхийн дундаж өртгийг 5 хувь хүртэл бууруулах Их 20-ийн амлалт, 2030 он гэхэд дэлхийн дундажийг 3 хувь хүртэл бууруулах НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтууд багтах бөгөөд ингэснээр илгээж буй мөнгөн гуйвуулгын дүнгийн 5 ба түүнээс доош хувиар шимтгэл төлөх нөхцөл бүрдэх юм.

<sup>17</sup> ТЗЗДБХ-ны Хил дамнансан жижиглэнгийн төлбөрийн тухай тайлан, 2018 он, ТЗЗДБХ-ны 2020 оны Хил дамнансан төлбөр тооцоог сайжруулах нь: Дэлхийн замын зураглалын суурь үндэс баримт бичгийг үзнэ үү?

## Монгол Улсын нөхцөл байдал

**75. Монгол Улсад хил дамнасан гүйлгээний эдийн засгийн ач холбогдлыг нэмэгдүүлэхэд нөлөөлж буй гол хүчин зүйл нь олон улсын болон цахим худалдаа өсөж байгаа явдал юм.** Монгол Улс харьцангуй жижиг, нээлттэй эдийн засагтай бөгөөд гадаад худалдаа 2020 оны байдлаар ДНБ-ий 14 хувийг эзэлж байна.<sup>18</sup> 2020 онд нийт бараа, үйлчилгээний импорт ДНБ-ий 54.6 хувьтай, бараа, үйлчилгээний экспорт 60 орчим хувьтай тэнцүү байна.<sup>19</sup> Amazon, eBay, Alibaba болон бусад платформуор дамжуулан онлайн худалдаа хийх явдал өссөнөөр Монголын хэрэглэгчид болон байгууллагын худалдан авагчдад онлайнаар худалдан авсан бараа, үйлчилгээний төлбөрийг төлөх төрөл бүрийн зохицуулалт, төлбөрийн хэрэгслийг хөгжүүлэхэд гол түлхэц болж байгаа юм.

**76. Монгол Улс мөнгөн гуйвуулга хүлээн авагч орон ба 2020 оны байдлаар ДНБ-ий 4.2 хувьтай тэнцэх хэмжээний гуйвуулгыг гадаадад ажиллагсадаас хүлээж авсан байна.**<sup>20</sup> Монгол руу шилжүүлсэн мөнгөн гуйвуулгын хэмжээ 2017 оноос өмнө харьцангуй тогтвортой байсан бөгөөд 2017 онд 269 сая ам.доллартай тэнцэх хэмжээний мөнгөн гуйвуулга хүлээж авч байсан. Харин энэ тоо 2018, 2019 онд тус тус 440 сая, 561 сая ам.долларт хүрч огцом өссөн ч КОВИД-19 цар тахалтай холбоотой дэлхийн эдийн засгийн нөхцөл байдлын улмаас 2020 онд 549 сая ам.доллар болж бага зэрэг буурсан байна.<sup>21</sup> Монгол Улсын 130 мянга орчим иргэн гадаадад амьдарч,<sup>22</sup> 25 мянга гаруй монгол оюутан гадаадад, гол төлөв Ази тивд суралцаж байна.<sup>23</sup>

**77. Монгол Улсаас мөнгө гуйвуулга илгээх, хүлээн авах зардлын талаарх нэгдсэн мэдээллийн сан байхгүй байна.** Ихэнх банкууд өөрийн цахим хуудсанд Монголоос мөнгө шилжүүлэхтэй холбоотой шимтгэл хураамжийн мэдээллийг байршуулсан байдаг бөгөөд банкны шимтгэл нэлээд өндөр байдаг. Жишээлбэл харьцангуй бага дүнтэй (200 ам. доллартай тэнцэх) гүйлгээ хийхэд корреспондент банкны үйлчилгээтэй холбоотойгоор үнийн дүнгийн 18-28 хувийг шимтгэлд авдаг байна. Олон улсын мөнгөн гуйвуулгын операторуудын сүлжээгээр дамжуулж хийсэн гүйлгээний хураамж 6-8 хувийн хооронд хэлбэлзэж байгаа бол зарим улс руу гуйвуулга хийхэд 3 орчим хувийн шимтгэл авдаг үйлчилгээ үзүүлэгчид мөн үйл ажиллагаа явуулж байна. Гэвч эдгээр шимтгэл хураамжид төгрөгийг тухайн улсын валют руу хөрвүүлэх ханшийн зөрүү ороогүйг энд тэмдэглэх нь зүйтэй.

**78. Монгол дахь банк бус гуйвуулгын үйлчилгээ үзүүлэгчид нь жижиглэнгийн төлбөрийн системийн оролцогч болох боломжтой.** Банк бус мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэгчид Монголбанкны хариуцан ажиллуулдаг жижиглэнгийн төлбөрийн системийн (АСН+ болон картын нэгдсэн сүлжээ) оролцогч болох боломжтой боловч Монголбанк дээр төлбөр тооцооны данс нээх боломжгүй тул төлбөр тооцооны төлөөлөгч банктай хамтран ажиллах шаардлагатай. Энэ нь тэдний төлбөрийн үйлчилгээний зах зээл дээрх өрсөлдөх чадвар, шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээ гаргахад тодорхой хэмжээгээр саад учруулж байна.

**79. Монгол дахь мөнгөн гуйвуулгын зах зээлд давуу эрхийн гэрээ үйлчилсэн хэвээр байна.** Монгол улсаас илгээх, хүлээн авах мөнгөн гуйвуулгын дийлэнх хувийг хийдэг олон улсын мөнгө гуйвуулгын операторууд (МГО) нь өөрийн үйлчилгээгээ хүртээмжтэй байлгах зорилгоор арилжааны банкуудтай хамтран ажилладаг. Олон улсын МГО, Монголын банкууд

<sup>18</sup> Дэлхийн банк, 2020. <https://data.worldbank.org/indicator/NE.TRD.GNFS.ZS?locations=MN>

<sup>19</sup> Дэлхийн банк, 2020. Экспорт: <https://data.worldbank.org/indicator/NE.EXP.GNFS.ZS?locations=MN>; Imports: <https://data.worldbank.org/indicator/NE.IMP.GNFS.ZS?locations=MN>

<sup>20</sup> Дэлхийн банк, 2020. <https://data.worldbank.org/indicator/BX.TRF.PWKR.DT.GD.ZS?locations=MN>

<sup>21</sup> Дэлхийн банк, 2020. <https://data.worldbank.org/indicator/BX.TRF.PWKR.CD.DT?locations=MN>

<sup>22</sup> Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага (ОУШХБ)

<sup>23</sup> БҮЯОУЗ Хяналт 2019 оны 9 дүгээр сар <https://monitor.icef.com/2019/09/mongolian-outbound-higher-than-estimated-most-of-it-going-to-asian-powerhouses/> Mongolian outbound higher than estimated, most of it going to Asian powerhouses (icef.com)

хоорондын ихэнх хамтын ажиллагаа нь давуу эрхийн гэрээтэй, хязгаарлалт хийсэн шинжтэй байдаг. Энэ төрлийн гэрээ нь өрсөлдөөнийг хязгаарлаж, үйлчилгээний өртгийг нэмэгдүүлж, үйлчилгээний цэгүүдийг тэлэх боломжийг хязгаарладаг.

**80. Монголын худалдаа үйлчилгээний байгууллагууд хил дамнасан цахим худалдааны гүйлгээ хүлээн авахад ихээхэн бэрхшээлтэй тулгардаг.** Цахим худалдааны гүйлгээний олон улсын ихэнх гарцууд Монголд байхгүй тул Монголбанк олон улсын үйлчилгээ үзүүлэгч компаниудтай холбоо тогтоон, яриа хэлцэл хийж эхлээд байна.

**81. Монголын банкууд корреспондент банкны харилцаагаа хадгалахад ихээхэн бэрхшээлтэй тулгарч байна.** Үүний гол шалтгаан нь олон улсын эрсдэлтэй ангилалд орсон харилцагчидтай тогтоосон харилцаагаа цуцлах, хязгаарлалт тогтоох чиг хандлага болон 2019 онд Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага (ФАТФ) Монгол Улсыг саарал жагсаалтад оруулсан явдал юм.

### **Зорилго ба гол арга хэмжээ**

#### **ЗОРИЛГО # 9: ХИЛ ДАМНАСАН ЖИЖИГЛЭНГИЙН ТӨЛБӨР ТООЦООНЫ ҮР АШИГ, ХҮРТЭЭМЖ, ИЛ ТОД БАЙДЛЫГ НЭМЭГДҮҮЛЖ, ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ**

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа 1.** Цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээг дэмжин ажиллаж, зөвшөөрөлтэй үйлчилгээ үзүүлэгч төлбөрийн системийн дэд бүтэц рүү холбогдох, оролцогч болох нөхцөлийг бүрдүүлж ажиллах;

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа 2.** Монгол Улсын мөнгөн гуйвуулгын зах зээлд давуу эрхийн гэрээ үйлчилж буй эсэхэд хяналт тавьж, шаардлагатай гэж үзвэл тэдгээрийг хязгаарлах арга хэмжээ авах;

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа 3.** Мөнгөн гуйвуулгын урсгал, шимтгэл хураамжийн талаарх мэдээллийг тогтмол цуглуулж, олон нийтэд ил тод мэдээлэх;

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа 4.** Олон улсын цахим худалдааны гарц, Монголын худалдаа үйлчилгээний байгууллага хоорондын хамтын ажиллагааг бий болгох үүднээс үйлчилгээ үзүүлэгчидтэй холбоо тогтоох, хамтран ажиллах боломжийг эрэлхийлэх;

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа 5.** Аж ахуйн нэгж, иргэд хил дамнасан гүйлгээ хийхэд тулгардаг, шимтгэл хураамж, хурд, ил тод байдал, хүртээмж, хууль эрх зүйн хязгаарлалт, төлбөрийн системийн дэд бүтэцтэй холбоотой гарч байгаа бэрхшээл, асуудалд дүн шинжилгээ хийх;

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа 6.** Дээрх дүн шинжилгээнд үндэслэн гарч буй асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх.

## 4 Хэрэгжүүлэх төлөвлөгөө

82. **Монгол Улсын ҮТС-ийг хөгжүүлэх стратегийг ирэх 5 жилийн хугацаанд (2022-2026 он) үе шаттайгаар хэрэгжүүлэх** бөгөөд төлөвлөгөөний үе шатыг тухайн хэрэгжүүлэх үйл ажиллагааны ач холбогдол, нөөц бололцоог харгалзан үзсэний үндсэн дээр тодорхойлов. Ойрын хугацаанд хийгдэх ажлуудыг нэг жилийн дотор хийсэн байх шаардлагатай бол богино хугацааны ажлуудыг 2-3 жил, дунд хугацааны ажлуудыг 5 жилийн дотор тус тус гүйцэтгэсэн байх шаардлагатай. Стратегийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг эмхэтгэн Хүснэгт 2-т тусгасан болно.

83. **Монголбанк нь стратегийн хэрэгжилтийг хангахтай холбоотойгоор СЯ, СЗХ зэрэг эрх бүхий байгууллага хоорондын ажлын уялдаа холбоог хангахад голлох үүрэг гүйцэтгэнэ.** Хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тухайн үйл ажиллагааг цаг тухайд нь, үр дүнтэй хэрэгжүүлэх үүргийг Монголбанк, Сангийн яам, СЗХ, холбогдох бусад байгууллагад хуваарилсан. Мөн ҮТС-ийн стратегийн хэрэгжилтийг хангахад тодорхой зохион байгуулалтыг хийж, хүний нөөцийг томилсон байх явдал чухал.

84. **ҮТС-ийн зөвлөл нь стратегийн хэрэгжилт, төлбөрийн системийн шинэчлэлтэй холбоотой хэлэлцүүлэг, хамтын ажиллагаанд тогтмол оролцоотой байна.** Стратегийн хүрээнд хувийн хэвшлийн хийж гүйцэтгэх үйл ажиллагааг ҮТС-ийн Зөвлөлөөр дамжуулан мөн хоёр болон олон талт хамтын ажиллагааны хэлбэрээр зохион байгуулна. Монголбанк жил бүр стратеги хэрэгжилтийн явцын тайлан гаргаж, үйл явц, гарч буй үр дүнд хяналт тавина. Шаардлагатай тохиолдолд хэрэгжүүлэх төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулж болно. Дунд хугацааны иж бүрэн үнэлгээг 2024 онд, стратегийн хэрэгжилтийн эцсийн үнэлгээг 2026 онд тус тус хийнэ.

85. Улсын төсөв, олон улсын болон дотоодын байгууллагын санхүүгийн дэмжлэг, төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчдийн хөрөнгө оруулалт зэрэг эх үүсвэрээс стратегийг хэрэгжүүлэх санхүүжилтийг гаргана.

**Монгол Улсын ҮТС-ийг 2022-2026 онд хөгжүүлэх стратегийг Хэрэгжүүлэх төлөвлөгөөг эмхэтгэн дараах хүснэгтэд тусгасан болно.**

Хүснэгт 2. УТС-ийг 2022-2026 онд хөгжүүлэх стратегийг Хэрэгжүүлэх төлөвлөгөө

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Дэд буюу дагалдах арга хэмжээ	Хариуцах байгууллага	Эрэмбэ дараалал/ хэмжээ
<b>СТРАТЕГИЙН I БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ</b>				
<b>Зорилго #1: Төлбөр тооцооны систем, төлбөрийн хэрэгсэл болон төлбөрийн үйлчилгээний хууль эрх зүй, зохицуулалтын орчныг бэхжүүлэх</b>				
1	Банк бус төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчдэд тавих хяналт, шалгалтын уялдаа холбоог сайжруулах зорилгоор одоо мөрдөгдөж буй хуулиудад дүн шинжилгээ хийж, нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг өргөн барих;	- УТС тухай хууль болон дагалдах бусад хуулиудад дүн шинжилгээ хийх - Хуульд нэмэлт өөрчлөлт оруулах санал бэлтгэн, УИХ-д өргөн мэдүүлэх	Монголбанк, СЗХ	Богино хугацаанд
2	Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч, системийн операторт зөвшөөрөл олгох, хяналт тавих үйл ажиллагааг цогцоор нь зохицуулсан нэгдсэн журам гаргах:	- Цогц журмын төслийг боловсруулж батлуулах - Журмын тайлбар баримт бичиг гаргах		Ойрын хугацаанд
3	Инновацийг дэмжиж, төлбөрийн зах зээлд гарч ирж буй шинэ төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээг хамруулсан, түүнтэй холбоотой гарч ирэх эрсдэлийг үр дүнтэй удирдах төлбөрийн системийн хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх;	- Шаардлагатай журам зааварт тухай бүр өөрчлөлт оруулах	Монголбанк	тогтмол
4	Санхүүгийн мэдээллийг банк, банк бус төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нар солилцон, харилцан ашиглах		Монголбанк	Дунд хугацаанд

	боломжтой нээлттэй банкны (open banking) үйлчилгээг дэмжсэн хууль эрх зүйн зохицуулалт бий болгох хэрэгцээ шаардлагыг судлах;			
5	Санхүүгийн салбарын харилцагчдыг хамгаалах тухай шинэ хуультай холбоотойгоор, банк бус төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч, төлбөрийн хэрэгсэл гаргагч нарт тавигдаж буй хэрэглэгчийн эрхийг хамгаалах шаардлагад нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай эсэхийг үнэлэх		Монголбанк	Ойрын хугацаанд
6	Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай шинэ хуультай нийцүүлэн төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нарт тавигдах мэдээллийн нууцлал, аюулгүй байдлын талаар нэмэлт шаардлагыг холбогдох журмуудад тусгах шаардлагатай эсэхийг үнэлэх		Монголбанк	Ойрын хугацаанд
<b>Зорилго #2: Монгол улсын үндэсний төлбөрийн системийг бүхэлд нь үр дүнтэй хянах</b>				
1	Шаардлагатай тохиолдолд Төлбөрийн системийн хяналтын бодлогыг шинэчлэх		Монголбанк	Дунд хугацаанд
2	Оролцогч, операторуудаас авч буй тайлан, тоон мэдээг нягталж, шаардлагатай нэмэлт статистик мэдээллийг олж тодорхойлох	- Тайлангийн загварт хүйсээр ангилсан мэдээлэл болон бусад шаардлагатай мэдээллийг оруулж, шинэчлэн батлах	Монголбанк	Ойрын хугацаанд

3	Төлбөрийн системтэй холбоотой авч буй тайлан мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх ажлыг автоматжуулах		Монголбанк	Богино хугацаанд
4	Төлбөр тооцооны газрын хянан шалгагч, бодлогын мэргэжилтний нөөцийг нэмэгдүүлж, шинээр гарч ирж буй эрсдэл, төлбөрийн системийн чиг хандлага, шинэлэг төлбөрийн хэрэгсэл, схемүүд болон үр дүнтэй хяналт тавих олон улсын стандартын талаар өргөн хүрээний ойлголт өгч, техникийн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн чадавх бэхжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх		Монголбанк	Дунд хугацаанд
<b>Зорилго #3: Жижиглэнгийн төлбөрийн систем, хэрэгслүүд болон үйлчилгээний олон улсын хяналтын стандарт нэвтрүүлэх</b>				
1	СЗЗДБЗ-ын дагуу Банксүлжээ систем, Төв банкны үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн үйл ажиллагаанд хийх үнэлгээг тогтмол хийх		Монголбанк	Тогтмол
2	Олон улсын стандарт, шилдэг туршлагад нийцүүлэн жижиглэнгийн төлбөрийн систем, төлбөрийн хэрэгсэл, үйлчилгээ, тэр дундаа шинэлэг төлбөрийн хэрэгсэл, схемд зориулсан стандартуудыг нэвтрүүлэх	- Шаардлагатай стандартуудыг боловсруулж, батлуулах	Монголбанк	Дунд хугацаанд
3	Жижиглэнгийн төлбөрийн систем, төлбөрийн хэрэгсэл, үйлчилгээ нь	- Тохирох зарчмуудыг тодорхойлж, албажуулах	Монголбанк	Дунд хугацаанд

	стандартад нийцэж байгаа эсэх үнэлгээг тогтмол хийх	- Үнэлгээг тогтмол хийх		
<b>Зорилго #4: Эрх бүхий байгууллагууд хоорондын болон салбарын бусад байгууллагуудтай хамтран ажиллах зохицуулалтыг сайжруулах</b>				
1	Мэдээлэл солилцох, хяналт шалгалтын хүрээнд хамтран ажиллах талаар нарийвчлан тусгасан санамж бичиг байгуулах	- Одоогийн санамж бичигт дүн шинжилгээ хийж, нэмэлтээр тусгах саналыг боловсруулах - Санамж бичгийг шинэчлэн байгуулах	Монголбанк, СЗХ	Богино хугацаанд
2	Тайлан, мэдээлэл солилцох, хамтарсан хяналт шалгалтыг үр ашигтай зохион байгуулж, хэрэгжүүлэх		Монголбанк, СЗХ, ХХЗХ	Тогтмол
3	ҮТС-ийн Зөвлөл: ҮТС-ийн шинэчлэлийг хэрэгжүүлэх; Монголбанк: Мэдлэг, туршлагаа хуваалцах		ҮТС-ийн Зөвлөл, Монголбанк	Дунд хугацаанд
<b>СТРАТЕГИЙН II БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ</b>				
<b>Зорилго #5: ҮТС-ийн үр ашигтай, аюулгүй, найдвартай, тасралтгүй үйл ажиллагааг хангах</b>				
1	Эрсдэлийн удирдлагын цогц баримт бичгийг боловсруулж, эрсдэлийн гол үзүүлэлтүүдийг тогтмол хянах		Монголбанк	Богино хугацаанд
2	Монголбанкны хариуцан ажилладаг системүүдийн цахим аюулгүй байдлын эрсдэлийг удирдах, хянах, бууруулах зорилгоор үнэлгээ хийж, стратеги	- Системийн цахим аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг хийх	Монголбанк	Дунд хугацаанд

	төлөвлөгөө боловсруулах ба цахим аюулгүй байдлын олон улсын стандартыг төлбөрийн системд нэвтрүүлэх	- Олон улсын стандартыг нэвтрүүлж, бодлогын баримт бичигт шаардлагатай өөрчлөлт оруулах		
3	Монголбанкны ажиллуулдаг системүүд, түүний оролцогчдод зориулсан Тасралтгүй ажиллагааны төлөвлөгөөг тогтмол шинэчлэх.	- Эрсдэлийн удирдлагын газар, Мэдээлэл технологийн газартай хамтран төлөвлөгөөг шинэчлэх	Монголбанк	Богино хугацаанд
4	Банксүлжээ систем, АСН+, Картын нэгдсэн сүлжээтэй холбоотой мэдээлэл солилцох, санал хүсэлтэд хариу зорилгоор Хэрэглэгчдийн группийг албан ёсоор байгуулах		Монголбанк	Богино хугацаанд
5	Банксүлжээ системийн оролцогчдын төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангуулах зорилгоор өдрийн зээл олгох үйл явцыг бүрэн автоматжуулах.		Монголбанк	Дунд хугацаанд
6	Монголбанкны цахим арилжааны системээс гадуурх валютын арилжааны гүйлгээний төлбөр тооцооны зохицуулалт, дотоодын зах зээл болон хил дамнасан гадаад валютын гүйлгээний урсгал, корреспондент банкны харилцаанд дүн шинжилгээ хийх.		Монголбанк, СЗХ	Богино хугацаанд
<b>Зорилго #6: ҮЦТТС болон ҮЦТХТ-ийн үйл ажиллагаанд санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн зарчмыг мөрдөх</b>				

1	МҮЦТХТ, МҮЦКС-ийг Санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн зарчмын дагуу мөнгөн хөрөнгийн клиринг, төлбөр тооцоотой хамааралтай хэсгийн үнэлгээ хийхэд хамтран ажиллах.	Хамтран ажиллах талаар санамж бичигт тусгаж албажуулах	Монголбанк, СЗХ	Дунд хугацаанд
<b>СТРАТЕГИЙН Ш БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ</b>				
<b>Зорилго #7: Инноваци, цахим төлбөрийн хэрэглээг нэмэгдүүлэх</b>				
1	Төлбөрийн зах зээл дэх инновацийг дэмжиж, зах зээлд төлбөрийн шинэ шийдлүүдийг бий болгоход дэмжлэг үзүүлэх арга хэрэгслүүдийг тодорхойлж хэрэгжүүлэх	- Инновацийн оффисийг бүрэн ашиглах - Сэндбоксийн зөвлөлийн үйл ажиллагаанд тогтмол идэвхитэй оролцох	Монголбанк, СЗХ	Ойрын хугацаанд
2	Төлбөр тооцоо хийх зардал, хэрэглэгчийн зан төлөв, түүнийг өөрчлөх хүчин зүйлс зэргийг багтаасан цахим төлбөрийн хэрэглээний талаарх иж бүрэн судалгааг хийх	- Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчдээс зардлын тоон мэдээг авах - Тоон мэдээнд дүн шинжилгээ хийж, шаардлагатай арга хэмжээг авах	Монголбанк	Богино хугацаанд
3	Үндэсний брэнд ₮ картыг EMV чип рүү бүрэн шилжүүлэхэд банкуудтай хамтран ажиллах		Монголбанк	2024 онд
4	Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчийн дансны дугаарлалт (IBAN), QR кодыг стандартчилах ажлыг гүйцэтгэх	- Дансны нэгдсэн дугаарлалтад бүрэн шилжих	Монголбанк	2024 онд

		- Төлбөрийн QR кодын стандартыг гаргах		
5	Цахим төлбөрийн бүтээгдэхүүн үйлчилгээ, түүний хэрэглээний талаар олон нийтийн боловсролыг дээшлүүлэхэд анхаарч ажиллах		Монголбанк	Дунд хугацаанд
<b>Зорилго #8: Засгийн газрын төлбөрийг цахимжуулах ажлыг үргэлжлүүлэх</b>				
1	Цахим Монгол хөтөлбөрийг дэмжиж, E-Mongolia платформоор хийгдэж буй бүх төлбөрийг цахим хэлбэрээр тасралтгүй, үр ашигтай, аюулгүй байдлаар дамжуулах нөхцөлийг бүрдүүлэх		Монголбанк	Дунд хугацаанд
2	Цахим төлбөр тооцоог стратегийн хувьд дэмжих зорилгоор Засгийн газрын төлбөрийг хөшүүрэг болгон ашиглана.		Монголбанк	Дунд хугацаанд
<b>Зорилго #9: Хил дамнасан жижиглэнгийн төлбөр тооцооны үр ашиг, хүртээмж, ил тод байдлыг нэмэгдүүлж, хэрэглэгчийн эрхийг хамгаалах</b>				
1	Цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээг дэмжин ажиллаж, зөвшөөрөлтэй үйлчилгээ үзүүлэгч төлбөрийн системийн дэд бүтэц рүү холбогдох, оролцогч болох нөхцөлийг бүрдүүлж ажиллах		Монголбанк	Дунд хугацаанд
2	Монгол Улсын мөнгөн гуйвуулгын зах зээлд давуу эрхийн гэрээ үйлчилж буй эсэхэд хяналт тавьж, шаардлагатай гэж		Монголбанк	Богино хугацаанд


	үзвэл тэдгээрийг хязгаарлах арга хэмжээ авах			
3	Мөнгөн гуйвуулгын урсгал, шимтгэл хураамжийн талаарх мэдээллийг тогтмол цуглуулж, олон нийтэд ил тод мэдээлэх	- СЗХ-той мэдээлэл солилцох үйл ажиллагааг албажуулах  - Мөнгөн гуйвуулгын урсгал, шимтгэл хураамжийн талаарх мэдээллийг тогтмол мэдээлэх	Монголбанк, СЗХ	Дунд хугацаанд
4	Олон улсын цахим худалдааны гарц, Монголын худалдаа үйлчилгээний байгууллага хоорондын хамтын ажиллагааг бий болгох үүднээс үйлчилгээ үзүүлэгчидтэй холбоо тогтоох, хамтран ажиллах боломжийг эрэлхийлэх		Монголбанк	Дунд хугацаанд
5	Аж ахуйн нэгж, иргэд хил дамнасан гүйлгээ хийхэд гарч буй бэрхшээл, асуудалд дүн шинжилгээ хийх.		Монголбанк, ҮТС-ийн Зөвлөл	Богино хугацаанд
6	Дээрх дүн шинжилгээнд үндэслэн гарч буй асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх.		Монголбанк	Дунд хугацаанд

## Хавсралт 1 – Арга зүй

### ҮТС-ийн шинэчлэлийн үйл явц

86. **ҮТС-ийн шинэчлэлийг дараах гурван үе шатыг үргэлжлүүлэн давтах байдлаар хэрэгжүүлдэг. (Зураг 5):** (i) Нөхцөл байдлын үнэлгээ хийх; (ii) Зорилго, холбогдох гол үзүүлэлтүүдийг тодорхойлж, ҮТС-ийн стратеги, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулах (iii) ҮТС-ийг хөгжүүлэх төлөвлөгөөг хэрэгжүүлэх, ахиц дэвшилд нь хяналт шинжилгээ хийх явц.

Зураг 5. ҮТС-ийн стратегийн үе шат



### 1 дүгээр үе шат – Нөхцөл байдлыг үнэлж дүгнэх

87. **Нөхцөл байдлын үнэлгээ хийх нь ҮТС-ийн стратегийг боловсруулах эхний чухал алхам юм.** Энэ шатанд холбогдох мэдээллийг цуглуулж, ҮТС-ийн одоо байгаа нөхцөл байдлын үнэлгээг олон улсын жишиг, шилдэг туршлагатай харьцуулан хийдэг.

88. **КОВИД-19 цар тахлын нөлөөгөөр энэхүү стратегийн нөхцөл байдлын үнэлгээг бүхэлд нь зайнаас хийж гүйцэтгэлээ.** Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр хийсэн судалгааг ашиглан арилжааны банкууд, банк бус төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчид болон гуравдагч үйлчилгээ үзүүлэгч этгээдээ мэдээлэл цуглуулсан. Үүний дараа Монголбанк, Дэлхийн банкны хооронд хэд хэдэн удаагийн виртуал уулзалт хийгээд байна.

### 2 дугаар үе шат – ҮТС-ийг хөгжүүлэх Стратеги, төлөвлөгөөг боловсруулах

89. **Энэхүү стратегийг боловсруулахдаа ТЗЗДБХ-ны болон Үнэт цаасны хороодын олон улсын байгууллагын Техникийн хороо (ҮЦХОУБ), Дэлхийн банктай хамтран гаргасан олон улсын удирдамжуудыг ашигласан.** ТЗЗДБХ-Дэлхийн Банк хамтран гаргасан баримт бичгүүдийг хавсралтад тусгасан болно.

90. **ҮТС-ийг хөгжүүлэх стратеги, шинэчлэлийн төлөвлөгөө боловсруулахад дараах үндсэн шат дарааллыг баримталдаг.** Үүнд: (I) ҮТС-ийн стратегийн зорилго, зорилтуудыг тодорхойлох; (II) ҮТС-ийн зорилтот онцлогууд, ҮТС-ийн загварыг боловсруулахад баримтлах үндсэн зарчмуудыг тодорхойлох; (III) Амжилтын хүчин зүйлсийг тодорхойлох; (IV) Хэрэгжүүлэх стратегийг тодорхойлох; (V) Тэргүүлэх зорилтууд, зорилтот хугацааг тохирох.

91. **ҮТС-ийн шинэчлэлийг төлөвлөгөөг боловсруулахдаа өргөн хүрээний хүчин зүйлсийг авч үзэх шаардлагатай.** ҮТС-ийн тогтвортой хөгжлийг хангахын тулд зах зээлийн дэд бүтэц, хууль, эрх зүйн зохицуулалтын орчин, төлбөрийн хэрэгсэл, технологи, системийн загвар, түүнчлэн төлбөрийн дэд бүтэц болон институцийн зохицуулалтын хоорондын олон талт харилцан хамаарал зэрэг ҮТС-ийн гол элементүүдийг тусгайлан авч үзсэн байх шаардлагатай. Системийг хөгжүүлэх санал санаачилга нь шинээр гарч ирж буй төлбөр тооцооны хэрэгцээ шаардлага, эдийн засгийн боломж бололцоон дээр тулгуурласан байж стратегийн хувьд төлөвлөгдсөн, эрэмбэлэгдсэн байх ёстой.

92. **Төрөл бүрийн систем, зах зээлүүд хоорондын нарийн төвөгтэй байдал, харилцан хамаарлыг харгалзаж үзсэн.** Тухайлбал, их дүнтэй төлбөрийн систем болон төлбөрийн систем дэх төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангуулахад барьцаа болгон ашигладаг үнэт цаасны хадгалалт, клиринг болон гүйлгээний систем хоорондоо нягт уялдаатай. Мөн жижиглэнгийн төлбөрийн системүүд нь ихэнхдээ их дүнтэй төлбөр тооцооны системээр олон талт үр дүнгийн тооцооллын дагуу төлбөр тооцоогоо хийдэг тул жижиглэнгийн төлбөрийн системийн үр ашиг, аюулгүй байдал нь их дүнтэй төлбөрийн системээс салшгүй хамааралтай байдаг.

93. **Түүнчлэн, ҮТС зохистой ажиллахад зах зээлийн өрсөлдөөн, хамтын ажиллагаа, хэрэглэгчийн эрх ашиг хоорондын тэнцвэрт байдал чухал шаардлагатай.** Банк болон бусад төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч компаниуд төлбөрийн системийн дэд бүтцийг хамтран ашиглаж, үүнээс бий болох үр өгөөж, үр ашгийг хүртэхийн зэрэгцээ, зах зээл дэх байр суурь, үйлчлүүлэгчдийн төлөө өрсөлдөх ёстой. Үндэсний эрх ашгийн үүднээс үйлчилгээ үзүүлэгчид үр ашигтай ажиллах, үндэсний төлбөрийн системийн дэд бүтэц нь төлбөрийн үйлчилгээ үзүүлж буй төрөл бүрийн оролцогчдод нээлттэй байх явдал зайлшгүй чухал.

94. ҮТС-ийг хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулах талаарх ТЗЗДБХ-ны удирдамжийг товчлон Шигтгээ 1-т тусгав.<sup>24</sup>

### **Шигтгээ 1 ТЗЗДБХ-ны Үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэх ерөнхий удирдамж**

**Удирдамж 3.** Цогц байдлаар авч үзэх: үндэсний төлбөрийн системийн гол бүрэлдэхүүн хэсгүүд болон түүний хөгжилд нөлөөлөх гол хүчин зүйлсийг цогцоор нь ойлгож, төлөвлөх.

**Удирдамж 4.** Эрэлт хэрэгцээнд тулгуурлах: үндэсний төлбөрийн системийн бүх хэрэглэгчдийн төлбөрийн хэрэгцээ, эдийн засгийн чадавхыг тодорхойлж, үндсэн чиглэл болгох.

**Удирдамж 5.** Зорилго зорилтыг тодорхой эрэмбэд оруулах: үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэхтэй холбоотой зорилго, зорилтыг стратегийн дагуу эрэмбэлж, төлөвлөх.

**Удирдамж 6.** Хэрэгжүүлэлт хамгийн чухал: стратегийн төлөвлөгөөг үр дүнтэй хэрэгжүүлэх.

*3 дугаар үе шат: – ҮТС-ийг хөгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилт, хяналт шинжилгээний процесс*

95. Энэхүү шатанд шаардлагатай зохион байгуулалт, санхүүгийн нөөц, хяналт шинжилгээний зохицуулалтыг хийж, төлөвлөгөөг хэрэгжүүлэх аргыг сонгоно. Төлөвлөгөөний хэрэгжилт олон үе шат дамжиж, олон жил үргэлжилж болох учраас хэрэгжүүлэлтийн явц байдалд хийх хяналт шинжилгээ, үнэлгээ маш чухал юм. ҮТС-ийн гүйцэтгэлийг дүгнэх шалгуур үзүүлэлтийг тодорхойлох нь хэрэгжилтийн үндсэн элемент болно.

<sup>24</sup> ТЗЗДБХ-ны 2006 оны Үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэхэд зориулсан ерөнхий удирдамж

## Хавсралт 2: YTC-ийн хөгжлийг хэмжих шалгуур үзүүлэлтүүд

<i>Үзүүлэлт</i>	<i>Тайлбар</i>
<i>Хандалтын цэгүүд</i>	100,000 хүнд ногдох ПОС терминал, 100,000 хүнд ногдох QR кодоор төлбөр хүлээн авах мерчантын тоо, насанд хүрсэн 1000 хүнд ногдох банкны салбарын тоо.
<i>Хандалтын цэгүүд: Хамрах хүрээ</i>	Дээр дурдсан хэмжигдэхүүнүүдийг газарзүйн тодорхой бүс нутгаар (бүс нутаг, хот, хөдөө гэх мэт) ангилан гаргана.
<i>Төлбөрийн хэрэгслүүд</i>	Нэг хүнд ногдох дебит, кредит картын тоо, интернэт банк, мобайл банк хэрэглэгчийн тоо, нийт данс эзэмшигч дотор эзлэх хувь, цахим мөнгөний дансны тоо.
<i>Төлбөрийн хэрэгслүүд: Хамрах хүрээ</i>	Дээр дурдсан хэмжигдэхүүнүүдийг газарзүйн тодорхой бүс нутгаар (бүс нутаг, хот, хөдөө гэх мэт) ангилан гаргана.
<i>Төлбөрийн хэрэгслийн хэрэглээ</i>	ПОС терминал, АТМ-ээр хийсэн гүйлгээ, АТМ-аас бэлэн мөнгө авах гүйлгээний тоо, дүн, дебит, кредит картаар хийсэн гүйлгээ, сард 3 болон түүнээс дээш удаа интернэт банк, мобайл банк ашигладаг хэрэглэгчийн тоо, эзлэх хувь, цахим мөнгөний гүйлгээний тоо, дүн, бэлэн мөнгө, цахимаар хийсэн төлбөрийн харьцаа.
<i>Төлбөрийн хэрэгслийн хэрэглээ: Хамрах хүрээ</i>	Дээр дурдсан хэмжигдэхүүнүүдийг газарзүйн тодорхой бүс нутгаар (бүс нутаг, хот, хөдөө гэх мэт) ангилан гаргана.

## Хавсралт 3: ТЗЗДБХ-ҮЦХОУБ-аас гаргасан Санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн зарчмууд (СЗЗДБЗ)

### **Ерөнхий бүтэц**

#### **Зарчим 1: Эрх зүйн зохицуулалт**

Санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн (СЗЗДБ) тухайн улс орон дахь үндсэн үйл ажиллагаа нь эрх зүйн тодорхой, ил тод, хэрэгжихүйц зохицуулалттай байна.

#### **Зарчим 2: Засаглал**

СЗЗДБ нь үйл ажиллагааныхаа найдвартай, үр ашигтай байдлыг хангаж, санхүүгийн тогтвортой байдлыг дэмжсэн, олон нийтийн эрх ашиг, холбогдох этгээдийн зорилго, зорилтод нийцсэн тодорхой, ил тод засаглалттай байна.

#### **Зарчим 3: Эрсдэлийн удирдлагын нэгдсэн тогтолцоо**

СЗЗДБ нь хууль эрх зүйн, зээлийн, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын, үйл ажиллагааны болон холбогдох бусад эрсдэлийг цогцоор нь удирдах эрсдэлийн удирдлагын нэгдсэн тогтолцоотой байна.

#### **Зээлийн болон Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэлийн удирдлага**

#### **Зарчим 4: Зээлийн эрсдэл**

СЗЗДБ нь оролцогчдод олгосон зээлийн хүндрэл болон төлбөр тооцоо, клирингийн үйл ажиллагаанаас бий болж болзошгүй зээлийн эрсдэлийг бодитоор үнэлж, хянаж, удирдах шаардлагатай. СЗЗДБ нь оролцогч бүрд олгосон зээлийн хүндрэлээс найдвартай хамгаалах санхүүгийн хангалттай эх үүсвэртэй байх шаардлагатай. Түүнчлэн, илүү эрсдэл бүхий үйл ажиллагаатай эсхүл олон улс оронд системийн талаас нэн чухал үүрэг гүйцэтгэдэг Арилжааны төлбөр тооцооны төвийн (АТТТ-ССР) хувьд болзошгүй нөхцөл байдлаас гарах санхүүгийн хангалттай нэмэлт эх үүсвэртэй байх ёстой. Тухайлбал, зах зээлийн онцгой нөхцөл байдлын улмаас Арилжааны төлбөр тооцооны төвд (АТТТ-ССР) хамгийн том зээлийн эрсдэл учруулж болохуйц хоёр томоохон оролцогч болон тэдний охин компаниуд үүргээ биелүүлэх боломжгүй болох нөхцөл үүсэж болох юм. Бусад бүх Арилжааны төлбөр тооцооны төвийн (АТТТ-ССР) хувьд зах зээлийн онцгой нөхцөл байдлын улмаас хамгийн том зээлийн эрсдэл учруулж болохуйц томоохон оролцогч болон түүний охин компаниуд нь үүргээ биелүүлээгүйгээс үүсэх эрсдэлийг даван туулах хангалттай санхүүгийн эх үүсвэртэй байх шаардлагатай.

#### **Зарчим 5: Барьцаа хөрөнгө**

СЗЗДБ нь өөрийн болон оролцогчдынхоо зээлийн хүндрэлийг удирдах зорилгоор барьцаа хөрөнгө байршуулахыг, шаардлагатай бол зээлийн, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын, зах зээлийн эрсдэл багатай барьцаа хөрөнгийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй. Түүнчлэн, дэд бүтэц нь барьцаа хөрөнгийн үнэлгээний хорогдуулалтын тогтвортой хувь (haircuts) болон хөрөнгө төвлөрлийн хязгаар тогтоож, мөрдөх шаардлагатай.

#### **Зарчим 6: Маржин**

Арилжааны төлбөр тооцооны төв (АТТТ-ССР) нь эрсдэлд суурилсан, хяналт, үнэлгээнд тогтмол хамрагддаг, үр дүнтэй маржины систем ашиглан оролцогчдод олгосон зээлийн эрсдэлийг удирдана.

### **Зарчим 7: Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэл**

СЗЗДБ нь төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэлээ бодитоор үнэлж, хянаж, удирдах шаардлагатай. СЗЗДБ нь зах зээлийн онцгой нөхцөл байдлын үед төлбөрийн томоохон үүрэг хүлээсэн оролцогч, түүний охин компаниуд үүргээ биелүүлэх боломжгүй болох зэрэг болзошгүй нөхцөл байдал үүссэн үед ч тухайн өдөр боловсруулсан гүйлгээний төлбөр тооцоог аль болох өдөрт нь багтаан найдвартай хийхийн тулд төлбөр тооцоонд ашиглагдаж буй валют бүрээр хангалттай хэмжээний түргэн хөрвөх эх үүсвэр байршуулах нь зүйтэй.

#### ***Төлбөр тооцоо***

### **Зарчим 8: Төлбөр тооцоог эцэслэх**

СЗЗДБ нь төлбөр тооцоог хамгийн багадаа л тухайн өдрийн эцэс гэхэд гүйцэтгэсэн байх ёстой. Шаардлагатай эсхүл боломжтой тохиолдолд төлбөр тооцоог тухайн өдөрт нь багтаан эсхүл бодит цагийн горимоор гүйцэтгэж байх нь зүйтэй.

### **Зарчим 9: Мөнгөн хөрөнгөөр хийх төлбөр тооцоо**

СЗЗДБ нь аль болох төв банкин дахь мөнгөн хөрөнгөө ашиглан төлбөр тооцоог гүйцэтгэнэ. Төв банкин дахь мөнгөн хөрөнгийг ашигладаггүй тохиолдолд арилжааны банкин дахь мөнгөн хөрөнгөө ашигласнаас үүсэж болзошгүй зээлийн болон төлбөрийн чадварын эрсдэлийг бууруулж, хатуу хяналт тавих шаардлагатай.

### **Зарчим 10: Биет нийлүүлэлт**

СЗЗДБ нь биет бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбоотойгоор гүйцэтгэх үүргийг тодорхой зааж, үүнээс учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлж, хянаж, удирдана.

#### ***Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв болон хөрөнгийн дүнгээр солилцох төлбөр тооцооны систем***

### **Зарчим 11: Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв (ҮЦТХТ)**

ҮЦТХТ нь үнэт цаасны бүрэн бүтэн байдлыг хангах, тэдгээрийг найдвартай хадгалах, хамгаалах, шилжүүлэхтэй холбоотой эрсдэлийг бууруулах, удирдах үйл ажиллагааг зохицуулсан дүрэм, журамтай байна. Түүнчлэн, ҮЦТХТ нь үнэт цаасны шилжүүлгийг цахим бүртгэлээр хийж, үнэт цаасыг биетээр эргэлтэд оруулалгүй, биет бус хэлбэртэйгээр хадгалж байх ёстой.

### **Зарчим 12: Хөрөнгийн дүнгээр солилцох төлбөр тооцооны систем**

Хэрэв СЗЗДБ нь санхүүгийн хоёр талт үүрэг хариуцлагатай холбогдсон гүйлгээний (жишээлбэл, үнэт цаас, гадаад валютын арилжааны гүйлгээ) боловсруулалт хийдэг бол холбогдох гүйлгээний төлбөр тооцоо хийгдсэн тохиолдолд л тухайн гүйлгээний төлбөр тооцоог хийж үндсэн эрсдэлээс зайлсхийх шаардлагатай.

#### ***Үүргээ биелүүлэх боломжгүй болох үеийн удирдлага***

### **Зарчим 13: Оролцогч үүргээ биелүүлэх боломжгүй болсон үед дагаж мөрдөх дүрэм, журам**

СЗЗДБ нь оролцогч үүргээ биелүүлэх боломжгүй болсны улмаас үүсэх нөхцөл байдлыг зохицуулах тодорхой дүрэм, журамтай байна. Эдгээр дүрэм, журам нь хохирол алдагдлыг хязгаарлаж, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын хүндрэлд орохоос зайлсхийсэн цагаа олсон арга хэмжээг авах, хүлээсэн үүргээ цаашид биелүүлэх бололцоог тухайн СЗЗДБ-д олгоход чиглэгдсэн байна.

### **Зарчим 14. Харилцагчийн позиц, барьцаа хөрөнгийг тусгаарлан бүртгэх, шилжүүлэх**

Арилжааны төлбөр тооцооны төв нь оролцогчийнхоо харилцагч этгээдийн позиц, түүнтэй холбогдуулан байршуулсан барьцаа хөрөнгийг тусгаарлан бүртгэх, шилжүүлэх ажиллагааг зохицуулсан дүрэм, журамтай байна.

## ***Бизнесийн болон үйл ажиллагааны эрсдэлийн ерөнхий удирдлага***

### **Зарчим 15: Бизнесийн эрсдэл**

СЗЗДБ нь бизнесийн эрсдэлээ тодорхойлж, хянаж, удирдаж, томоохон алдагдал хүлээсэн тохиолдолд үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн, үйлчилгээгээ үзүүлсээр байхын тулд өөрийн хөрөнгөөс бүрдсэн түргэн хөрвөх хангалттай, цэвэр хөрөнгөтэй байна. Түүнчлэн, түргэн хөрвөх цэвэр хөрөнгө нь голлох үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой саатал гарсан зэрэг системийг сэргээн засварлаж, үйлчилгээгээ хэвийн үзүүлэхэд ямар ч үед хүрэлцэхүйц байх ёстой.

### **Зарчим 16: Кастодианы үйлчилгээ болон хөрөнгө оруулалтын эрсдэлүүд**

СЗЗДБ нь өөрийн болон оролцогчдынхоо хөрөнгийг найдвартай хамгаалж, тэдгээрийг удирдахад хугацаа алдсанаас үүсэх эрсдэлийг бууруулна. СЗЗДБ нь зээлийн, зах зээлийн, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэл хамгийн багатай хэрэгслүүдэд хөрөнгө оруулалт хийх ёстой.

### **Зарчим 17: Үйл ажиллагааны эрсдэл**

СЗЗДБ нь үйл ажиллагааны эрсдэлийн дотоод, гадаад боломжит хүчин зүйлсийг тодорхойлж, оновчтой бодлого, журам, систем, хяналтын механизмаар дамжуулан тэдгээрийн үр дагаврыг бууруулна. Систем нь аюулгүй байдал, үйл ажиллагааны найдвартай байдлыг өндөр түвшинд хангахаар төлөвлөгдсөн байхын зэрэгцээ ачаалал даан ажиллах хангалттай хүчин чадалтай байна. Тасралтгүй ажиллагааны төлөвлөгөө нь өргөн хүрээтэй томоохон саатал гарсан үед ч гэсэн тухайн СЗЗДБ-д үйл ажиллагааг цаг алдалгүй сэргээж, үүргээ биелүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдсэн байна.

## ***Хүртээмж буюу оролцоо***

### **Зарчим 18: Оролцогчид тавигдах шаардлага, шалгуур**

СЗЗДБ нь оролцогчдод шударга, нээлттэй оролцоог дэмжсэн, эрсдэлд суурилсан, олон нийтэд ил тод шаардлага, шалгуурыг тавина.

### **Зарчим 19: Шууд бус оролцогчтой холбоотой зохицуулалт**

СЗЗДБ нь шууд бус оролцогчидтой холбоотой зохицуулалтаас үүс болзошгүй эрсдэлүүдийг тодорхойлж, хянаж, удирдана.

### **Зарчим 20: СЗЗДБ-ийн хамтын ажиллагаа**

Бусад СЗЗДБ-тэй хамтын ажиллагаа бүхий СЗЗДБ нь хамтын ажиллагаатай холбоотой эрсдэлийг тодорхойлж, хянаж, удирдана.

## ***Үр ашиг***

### **Зарчим 21: Үр ашигтай ба үр дүнтэй байдал**

СЗЗДБ нь оролцогчдын болон тухайн зах зээлийн хэрэгцээ шаардлагыг хангахдаа үйл ажиллагааныхаа үр ашигтай, үр дүнтэй байдлыг хадгалах ёстой.

### **Зарчим 22: Харилцаа холбооны стандарт ба горим**

СЗЗДБ нь төлбөр тооцоо, клиринг, бүртгэлийн үйл ажиллагааныхаа үр ашигтай байдлыг хангахын тулд мэдээлэл харилцаа холбооны олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандарт, горимуудыг ашиглах буюу тэдгээрт нийцэн ажиллах шаардлагатай.

## ***Ил тод байдал***

### **Зарчим 23: Дүрэм, журам, мэдээллийн ил тод байдал**

СЗЗДБ нь тодорхой, цогц дүрэм, журамтай байх шаардлагатай бөгөөд оролцогчдод учирч болзошгүй эрсдэл, үйлчилгээний шимтгэл, хураамж болон бусад томоохон зардлын талаарх үнэн зөв ойлголт өгөх үүднээс хангалттай мэдээллээр хангана. Түүнчлэн, холбогдох дүрэм, журмуудыг олон нийтэд нээлттэй, ил тод байлгах ёстой.

**Зарчим 24: Арилжааны мэдээллийн сан (TR) дахь мэдээллийн ил тод байдал**

Арилжааны мэдээллийн сан (TR) нь холбогдох эрх бүхий байгууллага, олон нийтийг тэдний хэрэгцээ шаардлагад нийцсэн, цагаа олсон, үнэн зөв мэдээллээр хангана.

***Санхүүгийн зах зээлийн дэд бүтэцтэй холбоотойгоор Төв банк, зах зээлийн зохицуулагчид болон бусад байгууллагуудын хүлээх үүрэг хариуцлага***

**Хариуцлага А: СЗЗДБ-ийн зохицуулалт, хяналт, шалгалт**

СЗЗДБ нь төв банк, холбогдох бусад эрх бүхий байгууллагын оновчтой, үр дүнтэй хяналт, шалгалт, зохицуулалтад хамрагдах ёстой.

**Хариуцлага В: Зохицуулалт, хяналт, шалгалтын бүрэн эрх, нөөц бололцоо**

Төв банк, холбогдох бусад эрх бүхий байгууллага нь СЗЗДБ-ийг хянан шалгах, хяналт тавих, зохицуулалтаар хангах үүрэг хариуцлагаа үр дүнтэй гүйцэтгэхэд шаардлагатай бүрэн эрх, нөөц бололцоотой байна.

**Хариуцлага С: Бодлогын ил тод байдал**

Төв банк, холбогдох бусад эрх бүхий байгууллага нь СЗЗДБ-тэй холбоотой хяналт, шалгалт, зохицуулалтын бодлогоо ойлгомжтой тодорхойлж, нийтэд ил тод болгоно.

**Хариуцлага D: СЗЗДБ-ын хэрэглээ**

Төв банк, холбогдох бусад эрх бүхий байгууллага нь холбогдох, олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн СЗЗДБ-ын зарчмуудыг баримталж, нийцүүлэн мөрдүүлнэ.

**Хариуцлага E: Бусад эрх бүхий байгууллагатай хамтран ажиллах**

Төв банк, холбогдох бусад эрх бүхий байгууллага нь СЗЗДБ-ийн найдвартай, үр ашигтай ажиллагааг дэмжин үндэсний болон олон улсын түвшинд хамтран ажиллана.

## Хавсралт 4: ТЗЗДБХ-ҮЦХОУБ-аас гаргасан Санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн цахим аюулгүй байдлыг хангах удирдамж

Энэхүү баримт бичгийн зорилго (Удирдамж) нь СЗЗДБ-ийн цахим аюулгүй байдлыг хангах чадварыг сайжруулах удирдамж чиглэл өгөхөд оршино. Тодруулбал, энэхүү баримт бичиг нь ТЗЗДБХ-ҮЦХОУБ-ын Санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн зарчмуудад (PFMI), Засаглал (Зарчим 2), Эрсдэлийн удирдлагын нэгдсэн тогтолцоо (Зарчим 3), Төлбөр тооцоог эцэслэх (Зарчим 8), Үйл ажиллагааны эрсдэл (Зарчим 17) болон СЗЗДБ-ийн хамтын ажиллагаа (Зарчим 20)-ны хүрээнд нэмэлт удирдамж чиглэл болж өгнө.

Энэхүү удирдамжид эрсдэлийн удирдлагын таван үндсэн ангилал болон СЗЗДБ-ийн цахим аюулгүй байдлыг хангах хүрээнд авч үзвэл зохих гурван үндсэн бүрэлдэхүүн хэсгийг тодорхойлсон байна. Эрсдэлийн удирдлага нь засаглал; эрсдэлийг олж тогтоох; хамгаалах; илрүүлэх; хариу үйлдэл ба нөхөн сэргээх гэсэн 5 ангилалтай (Зураг 7). Үндсэн бүрэлдэхүүн хэсгүүд нь: туршилт; нөхцөл байдлын талаарх мэдлэг; болон суралцаж, хөгжих юм. Үйл ажиллагааны тасралтгүй найдвартай байдлын зорилтот үзүүлэлтэд хүрэхийн тулд энэхүү удирдамжийн эрсдэлийн удирдлагын ангиллыг цогцоор нь авч үзэх шаардлагатай.

Зураг 6 Цахим аюулгүй байдлыг хангах удирдамжийн бүрэлдэхүүн хэсгүүд



Уг удирдамж нь СЗЗДБ-үүдэд шууд чиглэгдсэн хэдий ч, СЗЗДБ-үүд аюулгүй байдлыг хангах зорилтууд, тэдгээрийн хэрэгжилтийн талаарх ойлголтыг сурталчлан таниулах, дэмжихийн тулд өөрийн оролцогчид болон бусад хамааралтай талуудтай хамтран ажиллах явдал чухал юм. СЗЗДБ-үүд нягт холбоо, хамааралтай байдаг тул тухайн дэд бүтцийн цахим аюулгүй байдлыг хангах чадвар нь харилцан холбоотой СЗЗДБ-үүд, үйлчилгээ үзүүлэгчид болон оролцогчдоос тодорхой хэмжээгээр хамаардаг.

## Хавсралт 5: Жижиглэнгийн төлбөр тооцооны цогц стратегийг боловсруулах удирдамж

Улс орнуудад жижиглэнгийн төлбөр тооцооны цогц стратегийг хөгжүүлэхэд ашиглах суурь бүтцийг Дэлхийн банкнаас боловсруулаад байна. Тус суурь бүтцийг Дэлхийн банк, ТЗЗДБХ, бусад олон улсын болоод үндэсний байгууллагуудын өнгөрсөн хугацаанд хийсэн судалгаануудыг нэгтгэх замаар, 100 гаруй улс орны төлбөрийн системийн шинэчлэлд дэмжлэг үзүүлэх явцдаа хуримтлуулсан Дэлхийн банкны олон улсын туршлагад үндэслэн боловсруулсан.

Энэхүү суурь бүтэц нь Үндэсний төлбөрийн системийн нийтлэг зорилгоос гадна жижиглэнгийн төлбөр тооцоотой холбоотой олон янзын төрийн бодлого, зорилтын хүрээг өргөжүүлэх бололцоог бий болгож байна. Авч хэрэгжүүлэх гэж буй төрийн бодлого зорилтын богино жагсаалт нь:

- Төлбөрийн үйлчилгээний хүртээмж, хялбар, хямд төсөр байдлыг дэмжих;
- Жижиглэнгийн төлбөр тооцооны хэрэгцээ шаардлагад нийцсэн төлбөрийн хэрэгслүүд болон механизмуудыг хөгжүүлэх үр ашигтай дэд бүтцийн хөгжлийг дэмжих;
- Нийгмийн хувьд хамгийн тохиромжтой төлбөрийн хэрэгслийн хэрэглээг дэмжих.

Эдгээр төрийн бодлого, зорилгод хүрэхийн тулд дараах удирдамжийг санал болгож байна. Үүнд:

**Удирдамж I:** Жижиглэнгийн төлбөр тооцооны зах зээл нь ил тод, төлбөр төлөгч болон хүлээн авагчийн ашиг сонирхлыг зохистой түвшинд хамгаалсан, зардал багатай байх шаардлагатай.

**Удирдамж II:** Жижиглэнгийн төлбөр тооцоо нь тодорхой санхүүгийн, харилцаа холбооны болон бусад төрлийн дэд бүтцүүдийг шаардана; эдгээр дэд бүтцийг жижиглэнгийн төлбөр тооцооны үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор бий болгох нь зүйтэй. Шаардлагатай дэд бүтцэд банк хоорондын цахим шилжүүлгийн систем, зээлийн хороо, мэдээлэл солилцох платформ, банк хоорондын их дүнтэй нэг бүрчилсэн төлбөр тооцооны систем, найдвартай харилцаа холбооны болон үндэсний хэмжээний дэд бүтцийн бэлэн байдал зэрэг орно.

**Удирдамж III:** Жижиглэнгийн төлбөр тооцоо нь тодорхой, ойлгомжтой, үл ялгаварласан мөн тэнцвэртэй хууль, эрх зүйн зохицуулалтын тогтолцоотой байна.

**Удирдамж IV:** Жижиглэнгийн төлбөр тооцооны салбарт хамтын ажиллагаа болон өрсөлдөөний зохистой тэнцвэрийг хангахын зэрэгцээ өрсөлдөөнт зах зээлийн нөхцөлүүдийг дэмжинэ.

**Удирдамж V:** Жижиглэнгийн төлбөр тооцоо нь зохистой засаглал болон эрсдэлийн удирдлагын тогтолцоотой байна.

**Удирдамж VI:** Төрийн эрх бүхий байгууллагууд нь жижиглэнгийн төлбөр тооцооны зах зээлийг үр дүнтэй хянаж, шаардлагатай тохиолдолд хөндлөнгөөс шууд оролцож болно.